



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

2021 он 04 дугаар
сарын 16-ны өдөр

Дугаар ХЭГ/1081

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Г.ТЭМҮҮЛЭН ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийн байдлын талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: 42 хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021506337

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
2021 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн
ХТ/106/... тоот албан бичгийн хавсралт

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН Г.ТЭМҮҮЛЭН НАРЫН ГИШҮҮДЭЭС МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Сүүний хангамжийг нэмэгдүүлэх, сүүний чиглэлийн өндөр ашиг шимтэй малын тоо толгойг нэмэгдүүлэх, үнийг тогтворжуулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар /аймаг, он тус бүрээр/:

1.1. Монгол Улсын Засгийн газраас мал аж ахуйн үйлдвэрлэлийг бүсчлэн төрөлжүүлж хөгжүүлэх, импортыг бууруулж, экспортыг дэмжих, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдийн эдийн засгийн үр өгөөжийг сайжруулах зорилгоор “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”, “Тариалангийн зарим бүс нутгийг тогтоох тухай” тогтоолыг тус тус баталж, газар тариаланг эрчимжсэн мал аж ахуйтай хослон хөгжүүлэх ажлыг эхлүүлээд байна.

2018 онд малын тэжээл тариалалтад зориулж 1.0 тэрбум төгрөг, зөгий үржүүлэгч аж ахуйн нэгжүүдэд 35.0 сая, сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгчдэд 509.0 сая, малын үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ эрхлэгчдэд 180.0 сая, бүгд 1.7 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгох ажлыг Засгийн газрын тусгай сан, Мал хамгаалах сангаар дамжуулан зохион байгуулсан.

Мөн Мах, сүүний анхдугаар аяныг эрчимжүүлэх зорилгоор мах, сүүний чиглэлийн үхэр үржүүлж буй аж ахуйн нэгжүүдэд хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлж, 2018 онд 800.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 52 аж ахуйн нэгжид олгох ажлыг зохион байгуулсан нь үр дүнгээ өгсөн гэж үзэж байна.

Энэ нь бэлтгэн нийлүүлсэн болон боловсруулсан сүүний хэмжээгээр тодорхойлогдох бөгөөд бэлтгэн нийлүүлсэн сүүний хэмжээ 2019 онд 1.0 сая литр болж өмнөх оноос 15.9 хувиар, нэг хүнд ногдох боловсруулсан шингэн сүүний үйлдвэрлэл 12.7 литр болж, өмнөх оноос 4.8 хувиар өссөн дүнгээр харагдаж байна.

Мөн өрөм, зөөхий 165.5 грамм болж 49.3 грамм буюу 42.5 хувиар, аарц 152.0 грамм болж 81.9 грамм буюу 2.2 дахин, ааруул 49.6 грамм болж 3.9 грамм буюу 8.5 хувиар, цэцгийн тос 63.9 грамм болж 18.8 грамм буюу 41.7 хувиар тус тус өссөн байна.

Бэлтгэн нийлүүлсэн сүү / сая.литр/

Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он	
Сүү, сая литр	508.5	338.4	529.9	588.0	765.4	874.4	891.5	919.5	902.4	1 074.2	
Үүнээс:	гүүний	51.6	32.1	49.3	55.8	75.0	85.1	86.2	94.3	112.0	
	үнээний	335.3	242.8	297.2	337.0	440.4	512.4	522.4	539.9	627.9	
	ингэний	4.5	4.0	6.4	8.3	9.3	9.0	10.2	10.4	11.3	
	хонины	38.2	22.4	60.2	64.5	84.7	95.2	99.1	99.7	103.8	120.8
	ямааны	79.0	37.2	116.9	122.4	156.0	172.6	173.6	175.2	149.8	202.3

Боловсруулсан сүү /сая.литр/

Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Боловсруулсан сүү, ** сая литр	19,3	33.8	42.7	53.2	50.1	71.2	69.6	63.3	86.6	135.0	165,1
Нийт үйлдвэрлэлд боловсруулсан сүүний эзлэх хувь	5.0	10.0	8.1	9.1	7.5	9.3	8.0	7.1	9.4	15.0	15.4

*** Боловсруулсан сүүнд шингэн сүү, зайрмаг, тараг, бяслаг, аарц зэргийг оруулан тооцсон.*

1.2. Мал сүргийн тоо толгой өсөхийн хирээр эрчимжсэн аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, өндөр ашиг шимтэй цэвэр үүлдрийн малыг сонгон үржүүлэх сонирхол, хандлага нэмэгдэж, сүү, махны болон хосолмол ашиг шимт үхэр, сүүний чиглэлийн ямаа, ихэрлэдэг удмын болон махны чиглэлийн хонь, мах-өөхний чиглэлийн гахай, мах, өндөгний чиглэлийн шувууг гадаадаас импортлон үржүүлж байна.

Гаалийн ерөнхий газраас авсан судалгаагаар сүүлийн 5 жилд үржлийн адуу 1754, цэвэр үүлдрийн үхэр 3932, үржлийн гахай 797, мах, ноосны болон ихэрлэдэг удмын хонь 3000, сүү, ноолуурын ямаа 286, хоногийн настай дэгдээхэй 1.1 сая толгой, үржлийн өндөг 12.0 сая ширхэг, гүн хөлдөөсөн үр 200.0 мянган тун буюу 52.4 кг-ийг тус тус улсын хилээр нэвтрүүлсэн байна.

Мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх, малын генийн санг хамгаалах, сайжруулах, малын үржүүлэг, биотехнологийн ажил, үйлчилгээг зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн хөгжүүлэх дэлхийн жишигт нийцсэн технологиор өргөн цар хүрээтэй явуулах үндэсний чадавхийг бий болгох зорилгоор Дархан-Уул аймгийн Хонгор сумын нутагт 22.3 га газарт томоохон бүтээн байгуулалтын ажлыг 2013-2017 онд хийж, 2018 онд үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Тус төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу өндөр ашиг шимт импортын бухны 38.9 мянга, Монгол улсад баталгаажсан дотоодын бухны 2.7 мянга, импортын хуц, ухнын 1.3 мянга, дотоодын хуц, ухнын 21.8 мянга нийт 64.7 мянган тун үрийг Монгол Улсын малын генийн санд хадгалж байна.

Мал сүргийн чанарыг сайжруулах, гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлын хүрээнд 2020 онд эрчимжсэн мал аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн захиалгаар сүү-махны чиглэлийн хосолмол ашиг шимт Симменталь, Алатау үүлдрийн үхрийн 2804 тун, сүүний чиглэлийн Хар тарлан үүлдрийн үхрийн 962 тун, махны чиглэлийн Хар ангус үүлдрийн үхрийн 2530 тун нийт 6310 тун үр, 1733 литр шингэн азот үйлдвэрлэн нийлүүлсэн.

Монгол улсад нутагшуулан үржүүлж байгаа Хар тарлан, Алатау, Герефорд, Сэлэнгэ зэрэг 4 үүлдрийн 10 бухнаас 8000 тун үрийг технологийн дагуу үйлдвэрлэж, үндэсний генийн санд хүлээж аваад байна.

Малын генийн санг хамгаалах, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор улсын хэмжээнд зохиомол хээлтүүлгийн аяныг зохион эхлүүлж, мал үржүүлгийн техникчдийн ажлыг идэвхижүүлэх, ажил мэргэжлийн уралдаан зарлаж, дүгнэх, хээл авалтын хувийг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллаж байна.

Уг ажлын хүрээнд Малын удмын сангийн үндэсний төвд хадгалагдаж буй гүн хөлдөөсөн болон хүйс жолоодсон үр, шингэн азотын үнийг шинэчлэн тогтоож, эрчимжсэн аж ахуй эрхлэгчдэд хөнгөлөлттэй үнээр олгох ажлыг зохион байгуулж байна.

1.3.Статистик үзүүлэлтээр улсын хэмжээнд сүүний чиглэлийн 2004 өрх, аж ахуйд үржүүлж буй үхрийн тоо 97.3 мянга, махны чиглэлийн 594 өрх, аж ахуйн үхрийн тоо 28.6 мянгад хүрч, 2008 оны үзүүлэлттэй харьцуулахад мах, сүүний чиглэлийн үхрийн тоо 5 дахин өссөн бөгөөд нийт үхрийн 25 хувь нь цэвэр үүлдрийн, 75 хувь нь тэдгээрийн эрлийз байна.

Саамын оргил үед цэвэр үүлдрийн нэг үнээнээс 18 литр, эрлийз нэг үнээнээс 8 литр сүү тус тус сааж байна.

Улсын хэмжээнд сүү боловсруулах 237 үйлдвэр, цех, 75 хөргөлтийн төв бүртгэлтэй үйл ажиллагаа явуулж байгаагаас Улаанбаатар хотод 16 үйлдвэр тогтмол үйл ажиллагаагаа явуулж байна.

Сүү боловсруулах томоохон хүчин чадал бүхий үйлдвэрүүд олон улсын чанарын болон хүнсний аюулгүй байдлын тогтолцоо нэвтрүүлсэн бөгөөд суурилагдсан хүчин чадлын 14-15 хувийг ашиглаж байна.

Хуурай сүүний импортын хэмжээг бууруулах, өвлийн улиралд сүү бэлтгэн нийлүүлсэн иргэн, аж ахуй нэгжид урамшуулал олгох зорилгоор Засгийн газрын 2020 оны 130 дугаар тогтоолоор “Сүү боловсруулах үйлдвэр, цехэд техникийн зохицуулалтын шаардлагад нийцсэн түүхий сүү нийлүүлсэн малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд мөнгөн урамшуулал олгох түр журам”-ыг баталж 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дараа оны 04 дүгээр сарын 01-ийг хүртэлх 5 сарын хугацаанд 1 литр сүүнд 500 төгрөгийн урамшуулал олгох ажлыг зохион байгуулж, 7.7 сая иргэн, аж ахуйн нэгжид 3.3 тэрбум төгрөгийн урамшууллыг олгоод байна.

№	Урамшуулал олгосон сар	Урамшуулалд хамрагдсан малчин, эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдийн тоо	Сүүний хэмжээ	Олгосон урамшуулал
1	2020 -11 сар	2.375.00	1.939.944.00	969.972.000.00
2	2020 -12 сар	1.659.00	1.533.489.00	766.744.500.00
3	2021 - 01 сар	1.548.00	1.419.259.00	709.629.500.00
		493.00	219.338.00	109.669.000.00
4	2021- 02 сар	1.717.00	1.576.414.00	788.207.000.00

	Нийт	7.792.00	6.688.444.00	3.344.222.000.00
--	------	----------	--------------	------------------

Асуулга 2. Малыг бордож, жилийн турш иргэдийг шинэ махаар хангахаар авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнгийн талаар /аймаг, сар тус бүрээр/:

2.1.Мах үйлдвэрлэлийн хэмжээ 2019 онд 545.0 мянган тоннд хүрсэн нь 10 жилийн өмнөх дүнгээс 2 дахин өссөн бөгөөд нийт үйлдвэрлэсэн махны 83.7 хувийг бэлчээрийн мал аж ахуйгаас, 0.15 хувийг эрчимжсэн аж ахуйгаас, 16.2 хувийг эрчимжсэн гахай, тахианы аж ахуйгаас үйлдвэрлэсэн байна.

Мах үйлдвэрлэлийн төрлийг 2009-2019 оны дунджаар тооцоход 21.4 хувийг адууны, 10.6 хувийг үхрийн, 1.9 хувийг тэмээний, 29.5 хувийг хонины, 20.4 хувийг ямааны мах тус тус эзэлж байна.

Бэлтгэн нийлүүлсэн мах /мян.тн/

Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Мах, нядалгааны жингээр ¹ мян.тонн	269.1	201.2	211.6	251.4	263.4	448.3	400.0	426.1	515.2	545.0
үүнээс:										
адууны мах	35.6	23.0	25.5	31.1	29.5	50.8	41.7	41.8	57.2	70.8
үхрийн мах	58.6	47.5	54.8	59.7	54.9	93.2	92.4	97.7	126.6	114.7
тэмээний мах	5.7	5.8	8.2	6.5	9.7	8.2	6.5	7.1	9.7	12.5
хонины мах	91.3	77.4	78.4	67.2	91.3	134.6	116.2	126.7	152.7	168.4
ямааны мах	77.6	49.1	44.7	56.3	60.5	86.3	76.9	80.8	83.6	89.6

¹ дайвар бүтээгдэхүүн, гахайн мах, тахианы мах, борцыг оруулж тооцсон.

Нийт мах үйлдвэрлэлд үхрийн махны эзлэх хувь буурч, адууны мах бэлтгэл нэмэгдсэн нь экспорттой холбоотой бөгөөд улсын хэмжээнд үйлдвэрлэж буй махны 49.9 хувийг хонь, ямааны мах эзэлж байна.

Боловсруулсан мах /мян.тн/

Үзүүлэлт	2009 он	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Боловсруулсан мах, мянган тонн	21.4	14.7	16.4	16.6	23.6	17.0	12.8	9.2	25.8	45.6	32.9
Нийт үйлдвэрлэлд боловсруулсан махны эзлэх хувь	8.0	7.3	6.5	6.3	7.9	5.8	2.9	2.3	6.1	8.9	6.0

2.2.Махны чиглэлийн өндөр ашиг шимт хонины үржлийн аж ахуй байгуулах зорилгоор 2018 онд төслийн сонгон шалгаруулалт зарлаж махны чиглэлийн үржлийн 621 эм хонь, 36 хуц, нийт 657 хонийг Франц Улсаас импортлож, тэдгээрийг нутагшуулан үржүүлж, 1300 толгойд хүрээд байна.

Шинэ хөдөө төслийн хүрээнд 2018 онд махны чиглэлийн Геррефорд үүлдрийн үржлийн өсвөр бух 25 толгой, Сэлэнгэ үүлдрийн үржлийн бух 100 толгой,

Баяд үүлдрийн үржлийн өсвөр хуц 160 толгой, Дархад үүлдрийн үржлийн өсвөр хуц 200 толгой, Эрчим хар үүлдрийн үржлийн өсвөр ухна 180 толгой, Герефорд үүлдрийн бухны гүн хөлдөөсөн үр 6.0 мянган тун, зохиомол хээлтүүлгийн 4 иж бүрдэл тоног төхөөрөмжийг 494.4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, 2019 онд махны чиглэлийн дээрх үүлдрийн малыг худалдан авахад нийт 671.7 сая төгрөгийн дэмжлэгийг Булган аймгийн иргэн, аж ахуй нэгжид олгосон байна.

**Эрчимжсэн аж ахуйн төрөлжилтийн чиглэл,
тэдгээрт үржүүлж буй малын тоо**

Он	Сүүний чиглэлийн үхрийн аж ахуй		Махны чиглэлийн үхрийн аж ахуй		Мах-ноосны чиглэлийн хонины аж ахуй	
	төрөлжсөн аж ахуйн тоо	үхрийн тоо	төрөлжсөн аж ахуйн тоо	үхрийн тоо	төрөлжсөн аж ахуйн тоо	үхрийн тоо
2010 он	649	21412	101	11307	128	101681
2015 он	1172	61981	248	20847	397	65768
2016 он	1472	60998	178	17698	174	91404
2017 он	1727	74077	236	28788	1511	353165
2018 он	1899	75217	330	23794	1687	440447
2019 он	2497	100904	475	33692	1591	459335
2020 он	2004	97329	594	28634	3041	482173

Мах, сүү, сүү-махны чиглэлийн өндөр ашиг шимт үхрийн тоог нэмэгдүүлэх зорилгоор 2008-2019 онуудад БНХАУ, Франц, Герман, Словак зэрэг орнуудаас махны чиглэлийн Лимузин, Ангус, Герефорд, сүү-махны хосолмол ашиг шимт Монтебиллъярд, Швицийн бор, сүүний чиглэлийн Хар тарлан, Голштейн зэрэг 2000 гаруй цэвэр үүлдрийн үхрийг импортолсон бөгөөд нийт 13.1 тэрбум төгрөг зарцуулсны 61.0 хувийг улсын төсвөөс, 29.0 хувийг эрчимжсэн аж ахуй эрхлэгчид өөрсдийн хөрөнгөөр худалдан авсан байна.

Дархан-Уул аймагт махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн цогцолбор аж ахуйг байгуулж Хонгор сумын Хар бэлчирт нутагшиж 2 дахь жилдээ 100 эхээс 93 тугал хүлээн авч бойжиж байна.

Цогцолборын үйл ажиллагааг хэвийн явуулах чиглэлээр худаг, уст цэгийг нэмэгдүүлэх, зоо-мал эмнэлгийн үйлчилгээ явуулах цэг байгуулах, өвөлжилтийн бэлтгэл хангуулах, гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх ажлыг орон нутгийн 38.3 сая төгрөгийн санхүүжилтээр шийдвэрлэн ажиллаж байна.

Тус аймагт 2019 оноос эхлэн махны чиглэлийн суффолк үүлдрийн хуцаар 750 эм хонинд хээлтүүлгийн ажлыг хийж, 250 төл хүлээн аваад байна.

Цаашид аймгийн хүн амын махны хэрэгцээг хангах зорилгоор махны чиглэлийн хурга үржүүлэх, бордох ажлыг явуулж байна.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ОХУ-аас сүүний, мах-сүүний чиглэлийн үхэр оруулж ирэх иргэдийн санаачилгыг дэмжих улмаар Дархан-Сэлэнгийн сүүний үхрийн фермерүүдийг түшиглэн сүү боловсруулах үйлдвэрийг байгуулахаар 5 га газрын асуудлыг шийдвэрлээд байна.

Цаашид хүн ам олноор төвлөрсөн нийслэлийн, аймгийн төвийн орчмын болон газар тариалангийн бүс нутагт эрчимжсэн мал аж ахуйн кластерын загвар аж ахуй, цогцолборыг бий болгох, энэ арга хэмжээнд олон улсын хөрөнгө

оруулагчид, мэргэжлийн холбоод, судлаачид, аж ахуй нэгжүүдийг татан оролцуулах, тэдгээрийг дэмжих чиглэлээр ажиллана.

2.3. Нийслэлийн хүн амыг стратегийн хүнсээр тогтвортой, хүртээмжтэй хангах арга хэмжээний хүрээнд орон нутгаас бэлтгэсэн чанарын шаардлага хангасан махыг 2019 онд 10.5 мянга, 2020 онд 4.0 мянга, 2021 онд 11.0 мянган тонныг тус тус нөөцөлж, тогтвортой үнээр худалдан борлуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлж байна.

Уг ажлын хүрээнд махны үнийг тогтвортой барих чиглэлийг баримталж хонины ястай мах 1 кг нь 6700, үхрийн ястай мах 7700, ямааны мах 6200 төгрөгөөр худалдаалагдаж байна.

Асуулга 3. Байгалийн тэжээлийг орлох таримал тэжээл тариалах, ногоон тэжээлийн нэр төрөл, чанар, хангалтыг нэмэгдүүлэх, тэжээлийн үнийг тогтворжуулах талаар хэрэгжүүлсэн ажлын үр дүн, үзүүлсэн дэмжлэгийн талаар /аймаг, он тус бүрээр/:

Дэлхийн дулаарал, цаг уурын өөрчлөлттэй холбогдуулан байгалийн давагдашгүй хүчин зүйл, болзошгүй эрсдлийн нөлөөг багасгах, мал сүргийн таваарлаг байдлыг сайжруулах хэрэгцээ шаардлагын үүднээс тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгалийн тэжээлийг орлох таримал тэжээлийг тариалах шаардлага бий болж байна.

Манай улс нийт тэжээл үйлдвэрлэлийн дийлэнх хувийг ойт хээр, өндөр уул, газар тариалангийн бүсээс бэлтгэдэг бөгөөд 2017 оны байдлаар тэжээлийн ургамал тариалах талбай 26.2 мянган га буюу өмнөх үеэс 5 дахин багассанаар ургац хураалт 10 дахин буурсан үзүүлэлттэй байсан.

Тэжээлийн ургамал тариалалтыг эрчимжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд 2018 онд 46.3 мянга, 2019 онд 43.8 мянга, 2020 онд 84.5 мянган га хүртэл нэмэгдүүлсэн байна.

Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих хөтөлбөрийн хүрээнд таримал тэжээл тариалах талбайн хэмжээг 100.0 мянган га-д хүргэхээр төлөвлөж, 2021 онд ногоон тэжээлийн үрийг орон нутагт хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх, тариалалтыг нэмэгдүүлэхээр ажиллаж байна.

Улсын Их Хурлаас 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдөр баталсан Нэмэгдсэн өртгийн албан татвар, Гаалийн албан татвараас чөлөөлөх тухай хуулийн дагуу мал, амьтны бүх төрлийн тэжээл, өвс, тэжээлийн үр, хүнсний улаанбуудайн үр зэргийг импортлоход нэмэгдсэн өртгийн албан татвар, гаалийн албан татвараас тус тус чөлөөлөхөөр заасан.

Уг ажлын хүрээнд малын тэжээл импортлох чиглэлээр 88 аж ахуй нэгжтэй 133.0 мянган тонн тэжээл импортлох Бодлогын гэрээг 2020 оны 12 дугаар сарын 18-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 06-ны хооронд байгуулж ажиллалаа.

Гаалийн байгууллагын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн мэдээгээр 68 аж ахуй нэгж 28.8 тэрбум төгрөгийн үнэ бүхий 42.3 мянган тонн бүх төрлийн малын тэжээл импортлосон бөгөөд бүх төрлийн малын тэжээл импортоход 1.44

тэрбум төгрөгийн гаалийн албан татвар, 3.02 тэрбум төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татвараас, нийт 4.5 тэрбум төгрөгийг татвараас чөлөөлсөн байна.

Асуулга 4. Үүлдэр угсаа, ашиг шим өндөр үзүүлэлт бүхий хээлтүүлэгч мал болон цөм сүргийг сумдад бий болгосон талаар хийсэн ажил, үзүүлсэн дэмжлэг, санхүүжилтийн талаар /аймаг, он тус бүрээр/:

4.1.Шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажлын ололтыг хянан магадлах, баталгаажуулах, бүс нутгийн онцлогт тохирсон, дасан зохицох чадвартай, бие даасан популяцийн тоог нэмэгдүүлэх ажлын хүрээнд орон нутгийн мэргэжлийн байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн судлаачидтай хамтран 2017-2020 онд шинээр 21 үүлдэр, омгийн мал “Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам”-ын шаардлагыг бүрэн хангаж

- Адууны 2 үүлдэр, 2 омог;
- Тэмээний 2 үүлдэр, 1 үржлийн хэсэг, 1 омог;
- Үхрийн 1 үүлдэр, 1 үүлдрийн хэсэг;
- Хонины 2 үүлдэр, 1 үржлийн хэсэг, 1 омог;
- Ямааны 4 үүлдэр, 3 омог тус тус ХХААХҮ-ийн сайдын тушаалаар тус тус баталгаажсан байна.

Үүний дүнд улсын хэмжээнд 56 баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүргээс бэлчээрийн малын чанарыг сайжруулах зорилгоор өсвөр хээлтэгч, хээлтүүлэгч бойжуулан тухайн бүс нутагт нь үндсэн сайжруулагчаар ашиглаж байна.

Баталгаажсан үүлдэр, омгийн малын тархалт /төрлөөр/

1. Адуу

№	Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил, шийдвэр	
			Аймаг, сум	Батлагдсан огноо
1	Монгол үүлдэр	Уналга-эдэлгээ	Бүх нутгаар	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
2	Галшар үүлдэр	Хурд-уналга-эдэлгээ	Хэнтий аймгийн Галшар, Баянхутаг	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/86 дугаар тушаал
3	Тэс үүлдэр	Хурд-уналга-эдэлгээ	Увс аймгийн Тэс, Зүүнговь, Баруунтуруун, Завхан аймгийн Тэс, Баянхайрхан, Баянтэс Хөвсгөл аймгийн Цэцэрлэг, Цагаан-Уул	ХХААХҮСайдын 2019 оны А-444 дүгээр тушаал
4	Дархад омог	Уналга-эдэлгээ-мах	Хөвсгөл аймгийн Улаан-Уул, Ханх, Ренчинлхүмбэ, Цагааннуур	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
5	Мянгад омог	уналга-эдэлгээ-хурд	Ховд аймгийн Мянгад	ХХААХҮСайдын 2018 оны А-190 дүгээр тушаал
6	Өндөршил омог	Хурд-уналга-эдэлгээ	Дундговь аймгийн Өндөршил	ХХААХҮСайдын 2019 оны А-445 дугаар тушаал

2. Тэмээ

№	Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил, шийдвэр	
			Аймаг, сум	Батлагдсан огноо
1	Монгол үүлдэр	Ноос-мах-уналга эдэлгээ	Бүх нутгаар	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
2	Төхөм тунгалагийн хүрэн үүлдэр	Ноос-мах-уналга эдэлгээ	Говь-Алтай аймгийн Шарга, Цээл, Төгрөг	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/96 дугаар тушаал
3	Ханын хэцийн хүрэн үүлдэр	Ноос-мах-уналга эдэлгээ	Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогт-Овоо, Булган	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/07 дугаар тушаал
4	Галбын говийн улаан үүлдэр	Ноос-мах-уналга эдэлгээ	Өмнөговь аймгийн Манлай, Ханбогд, Баян-Овоо	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/06 дугаар тушаал
5	Ламын гэгээний улаан үржлийн хэсэг	Сүү-ноос	Баянхонгор аймгийн Баянлиг, Богд, Баянговь, Жинст	ХХААХҮСайдын 2017 оны А-178 дугаар тушаал
6	Олдохын хүрэн бор омог	Мах-ноос	Дундговь аймгийн Хулд сум	ХХААХҮСайдын 2020 оны А-358 дугаар тушаал

3. Үхэр

№	Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил, шийдвэр	
			Аймаг, сум	Батлагдсан огноо
1	Монгол үүлдэр	Мах	Бүх нутгаар	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
2	Монгол үүлдрийн сарлаг	Сүү-махны	Архангай, Баянхонгор, Хөвсгөл, Өвөрхангай, Завхан Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
3	Сэлэнгэ үүлдэр	Мах	Сэлэнгэ аймгийн Сэлэнгэ, Хушаат, Цагааннуур	Хөдөө аж ахуйн сайдын 1984 оны 287 дугаар тушаал
4	Дорнод Монголын улаан үүлдэр	Мах	Дорнод аймгийн Халхгол, Сүхбаатар аймгийн Түмэнцогт	ХХААХҮСайдын 2019 оны А-507 дугаар тушаал
5	Буган халиун үүлдрийн хэсэг	Сүү-махны	Төв аймгийн Батсүмбэр	ХХААХҮСайдын 2020 оны А-218 дугаар тушаал

4. Хонь

№	Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил, шийдвэр	
			Аймаг, сум	Батлагдсан огноо
1	Монгол үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Бүх нутгаар	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал

2	Барга үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Дорнод аймгийн Хөлөнбуйр	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2012 оны А/126 дугаар тушаал
3	Үзэмчин үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан	Хөдөө аж ахуйн сайдын 1991 оны А/65 дугаар тушаал
4	Керей үүлдэр	Мах-Өөхний Бүдүүн ноост	Баян-Өлгий аймгийн Дэлүүн	Хөдөө аж ахуй, үйлдвэрийн сайдын 1999 оны А/27 дугаар тушаал
5	Байдраг үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Баянхонгор аймгийн Жаргалант	Хөдөө аж ахуйн сайдын 1983 оны А/81 дүгээр тушаал
6	Баяд үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Увс аймгийн Малчин, Зүүнговь, Хяргас, Тэс	Хөдөө аж ахуйн сайдын 1991 оны А/65 дугаар тушаал.
7	Говь-Алтай үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Говь-Алтай аймгийн Бугат, Цээл	Хөдөө аж ахуйн сайдын 1991 оны А/65 дугаар тушаал
8	Сартуул үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Завхан аймгийн Эрдэнэхайрхан	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2002 оны А/118 дугаар тушаал
9	Дархад үүлдэр	Мах-ноосны чиглэлийн Бүдүүвтэр ноост	Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/53 дугаар тушаал
10	Хангай үүлдэр	Ноосны чиглэлийн нарийн ноост	Сэлэнгэ аймгийн Цагааннуур Булган аймгийн Бүрэгхангай	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн сайдын 1990 оны А/29 дүгээр тушаал
11	Орхон үүлдэр	Ноосны чиглэлийн нарийвтар ноост	Сэлэнгэ аймгийн Цагааннуур, Орхон	Хөдөө аж ахуйн сайд, Шинжлэх ухаан дээд боловсролын хүрээлэнгийн захиралын 1961 оны хамтарсан 72/16 дугаар тушаал
12	Тал нутгийн цагаан үүлдэр	Ноосны чиглэлийн нарийвтар ноост	Хэнтий аймгийн Хэрлэн	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 1993 оны А/18 дугаар тушаал
13	Сүмбэр үүлдэр	Арьсны чиглэл Каракуль	Говьсүмбэр аймгийн Сүмбэр	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн сайдын 1990 оны А/29 дүгээр тушаал
14	Тамир үүлдрийн хэсэг	Мах-ноосны	Архангай аймгийн Ихтамир	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2001 оны тушаал
15	Ерөө үүлдрийн хэсэг	Мах-ноосны	Сэлэнгэ аймгийн Ерөө	Хөдөө аж ахуй, Сангийн аж ахуйн сайд нарын 1981 оны 286/304 дүгээр хамтарсан тушаал
16	Торгууд үүлдрийн хэсэг	Мах-өөхний	Ховд аймгийн Булган	Хөдөө аж ахуйн сайдын 1982 оны А/81 дүгээр тушаал
17	Хотонт үржлийн хэсэг	Мах-ноосны	Архангай аймгийн Хотонт	Хөдөө аж ахуйн сайдын 1996 оны 9/70 дугаар тушаал
18	Алтанбулаг үржлийн хэсэг	Махны	Төв аймгийн Алтанбулаг	Хөдөө аж ахуй үйлдвэрийн сайдын 1996 оны 9/70 дугаар тушаал
19	Жаргалант үржлийн хэсэг	Мах-ноосны	Төв аймгийн Жаргалант	Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн сайдын 1989 оны А/6 дугаар тушаал
20	Буриад омог	Мах-ноосны	Дорнод аймгийн Дашбалбар	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/94 дүгээр тушаал
21	Баянгол омог	Мах-ноосны	Өвөрхангай	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын

			аймгийн Баянгол	2015 оны А/60 дугаар тушаал
22	Сутай үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Ховд аймгийн Дарви	ХХААХҮСайдын 2017 оны А-175 дугаар тушаал
23	Цагаан –Уул үүлдэр	Мах-өөх-бүдүүвтэр ноосны	Хөвсгөл аймгийн Цагаан-Уул	ХХААХҮСайдын 2017 оны А-177 дугаар тушаал
24	Сайнцагаан омог	Мах-өөх-ноосны	Дундговь аймгийн Сайнцагаан	ХХААХҮСайдын 2019 оны А-491 дүгээр тушаал
25	Бүрэгхангай үржлийн хэсэг	Мах-ноосны	Булган аймгийн Бүрэгхангай	ХХААХҮСайдын 2020 оны А-219 дүгээр тушаал
26	Баянбулаг омог	Мах-бүдүүвтэр ноосны	Баянхонгор аймгийн Баянбулаг	ХХААХҮСайдын 2020 оны А-359 дүгээр тушаал

5. Ямаа

№	Үүлдэр, омог	Ашиг шимийн чиглэл	Цөм сүргийн байршил, шийдвэр	
			Аймаг, сум	Батлагдсан огноо
1	Монгол үүлдэр	Ноолуур	Бүх нутгаар	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн яамны сайдын 1990 оны А/69 дүгээр тушаал
2	Говь гурван сайхан үүлдэр	Ноолуур	Өмнөговь аймгийн Булган	Хөдөө аж ахуйн сайдын 1971 оны тушаал
3	Уулын бор үүлдэр	Ноолуур	Баян-Өлгий аймгийн Баяннуур, Дэлүүн, Булган	Хөдөө аж ахуй, хөнгөн хүнсний үйлдвэрийн сайдын 1991 оны А/23 дугаар тушаал
4	Завхан буурал үүлдэр	Ноолуур	Завхан аймгийн Дөрвөлжин	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/24 дүгээр тушаал
5	Залаа жинст Эдрэн үүлдэр	Ноолуур	Баянхонгор аймгийн Шинэжинст, Баян-өндөр	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2015 оны А/59 дүгээр тушаал
6	Алтайн улаан үүлдэр	Ноолуур	Ховд аймгийн Алтай, Үенч, Говь-Алтай аймгийн Бугат	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/87 дугаар тушаал
7	Баяндэлгэрийн улаан үүлдэр	Ноолуур	Сүхбаатар аймгийн Баяндэлгэр	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/05 дугаар тушаал
8	Өлгийн улаан үүлдэр	Ноолуур	Увс аймгийн Өлгий, Наранбулаг	ХХААХҮСайдын 2019 оны А-60 дугаар тушаал
9	Эрчим хар үүлдэр	Ноолуур	Хөвсгөл аймгийн Төмөрбулаг	ХХААХҮСайдын А-176 дугаар тушаал
10	Бөмбөгөрийн улаан омог	Ноолуур	Баянхонгор аймгийн Бөмбөгөр	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2016 оны А/88 дугаар тушаал
11	Өнжүүл үржлийн хэсэг	Ноос	Төв аймгийн Баян-өнжүүл	Хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний үйлдвэрийн сайдын 1982 оны А/457 дугаар тушаал
12	Галшарын улаан омог	Ноолуур	Хэнтий аймгийн Галшар	ХХААХҮСайдын 2018 оны А-189 дүгээр тушаал
13	Дэлгэрэхийн улаан омог	Ноолуур	Дорноговь аймгийн Дэлгэрэх	ХХААХҮСайдын 2019 оны А-61 дүгээр тушаал

Баталгаажсан үүлдэр, омгийн малын цөм сүрэг бүрдүүлэх, цөм сүрэг бүхий малчин өрхийг бий болгох ажлын хүрээнд 2020 оноос 21 аймгийн 183 суманд 6.6 мянган өрхийг цөм сүргээр батламжилж, 282.2 мянган малыг цөм сүрэгт бүртгээд байна.

Цаашид жил бүрийн үзлэг, ангилалтын дүнгээр цөм болон үржлийн сүргийн шаардлага хангасан малаар цөм сүрэг бүрдүүлж, үржлийн өсвөр мал бойжуулах ажлыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Баталгаажсан үүлдэр, омгийн цөм сүрэг бүхий өрх, малын тоо /аймгаар/

№	Аймгийн нэр	Сумын тоо	Цөм сүрэг бүхий малчин өрхийн тоо	Баталгаажсан үүлдэр, омгийн цөм сүрэг бүрдүүлэн ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх малын тоо					
				Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
1	Архангай	19	651	35800			7900	26200	1700
2	Баян-Өлгий	13	278	63881	110	480	1788	36539	24964
3	Баянхонгор	20	666	10750	600		1000	5200	3950
4	Булган	7	112	860			550	310	
5	Говь-Алтай	8	522	20000					20000
6	Говь-Сүмбэр	3	32	5195			195	3000	2000
7	Дархан-Уул	4	71	2800			750	2050	
8	Дорноговь	1	21	500					500
9	Дорнод	14	1579	1776			226	1050	500
10	Дундговь	15	60	7700	2000	1500	200	4000	
11	Завхан	23	259	13000		500	3500	4000	5000
12	Орхон	2	156	5250				3500	1500
13	Өмнөговь	13	816	6864	720	150	91	1053	4850
14	Өвөрхангай	5	277	12495	1000		6495	2000	3000
15	Сүхбаатар	3	34	7658			1742	5000	916
16	Сэлэнгэ	17	911	13950			5450	8500	
17	Төв	27	803	45600			2338	35078	8184
18	Увс	7	93	14000		2000		6000	6000
19	Ховд	7	198	10000		500	700	5000	3800
20	Хөвсгөл	5	22	3800				2800	1000
21	Хэнтий	2	37	600		100			500
Нэгдсэн дүн		183	6669	282229	4430	5230	32925	151280	88364

Дэлхийн хүн амын өсөлттэй уялдсан хүнсний эрэлт хэрэгцээг хангахын тулд дэлхийн улс орнууд нэгдэн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхэлж хүнс үйлдвэрлэх, үүний тулд генетик нөөцөө зөв ашиглаж, хамгаалах зорилгоор Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын дэргэд Мал, амьтны генетик нөөцийн асуудал хариуцсан Олон улсын хороо ажиллах болсон.

Мал, амьтны генетик нөөцийн олон улсын хороонд Европын холбооны улсуудаас гадна 178 орон нэгдсэнээс Монгол Улс малын генетик нөөцийн үйл ажиллагааны төлөвлөгөө, стратегийг идэвхижүүлэх шаардлагатай улсын тоонд

орсныг Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Малын генетик нөөцийн олон улсын хорооноос гаргасан тайланд тусгасан.

Иймээс Мал, амьтны олон янз байдлын олон улсын мэдээллийн санд Монгол Улсад баталгаажсан унаган үүлдэр, омгийн малын мэдээллийг оруулж, НҮБ-ын ХХААБ-ын Генетик нөөцийн үндэсний хороонд бүртгүүлээд байна.

Түүнчлэн Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайланг англи хэлнээ хөрвүүлэн хүргүүлэх ажлыг Монгол Улс дахь НҮБ-ын ХХААБ-ын Шадар суурин төлөөлөгчийн газартай хамтран хэрэгжүүлж байна.

4.2. Монгол Улсад үржүүлж буй үржлийн малын үнэт чанарыг үнэлэх, шилмэл, гойд ашиг шимт малыг тогтоож баталгаажуулах замаар монгол малын үнэ цэнэ, бүтээмжийг нэмэгдүүлж, нэгдсэн мэдээллийн санг үүсгэх зорилгоор Малын удам зүйн үнэлгээний нэгдсэн систем, muz.gov.mn хаяг бүхий цахим хуудсыг бий болгов.

Уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах 72.0 сая төгрөгийг дэмжлэгийг Дэлхийн банкны санхүүжилттэй хэрэгжсэн Хөдөө аж ахуй маркетинг төслөөс шийдвэрлэсэн байна.

Малын генетик нөөцийн тухай хуулийн хүрээнд Малын удам зүйн үнэлгээний программыг түшиглэн уламжлалт мэдлэгийн сан бүрдүүлэх ажлыг эхлүүлэн мал аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэх 56 уламжлалт мэдлэгийг бүртгэв.

Уламжлалт мэдлэгээр бүртгэгдсэн мэдээллийг <https://muz.gov.mn/> цахим хуудаст цувралаар нийтлэн олон нийтэд түгээн дэлгэрүүлж эхлээд байна.

Малчдын орлогыг бууруулахгүйгээр мал сүргийн тоо толгойг бэлчээрийн даацад тохируулах, сүргийн нөхөн үйлдвэрлэлийн төлөвлөлт, сүргийн бүтэц, эргэлтийг тооцох зорилгоор “Бэлчээрийн малын сүргийн эргэлтийг тооцох программ”-ыг ШХА-ийн санхүүжилтээр хэрэгжиж буй Ногоон алт-Малын эрүүл мэнд төслийн 60.0 сая төгрөгийн дэмжлэгээр боловсруулан бүх шатны мэргэжлийн байгууллагад хүлээлгэн өгөхөд бэлэн болоод байна.

Үүний үр дүнд бэлчээрийн монгол малын нөхөн үржихүйн норм, норматив, ашиг шим, бүтээгдэхүүн, түүхий эдийн стандарт үзүүлэлтийн дагуу тооцож, төлөвлөлтийг зөв хийх, жил бүр тодорхой хэсгийг эдийн засгийн эргэлтэд оруулах боломж бүрдэж байна.

4.3. Малын төрөл, ашиг шимийн чиглэлээр үржүүлэх бүс байршлыг тодорхойлж, селекцийн үр ашиг, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн төлөвлөлт, тоо толгойн өөрчлөлт, сүргийн эргэлтийг 10 жилээр тооцож, 2 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөсөн “Таван төрлийн малын үржлийн ажлын стратеги”-ийг боловсруулан бүх шатны мэргэжлийн байгууллагад хүргүүлэн мөрдөж ажиллаж байна.

Дэлхийн мал амьтны үнэт генетик нөөцөд хамаарагдах монгол орны үүлдэр, омгийн малыг цэврээр үржүүлэх, тэдгээрийн үнэт чанарыг бататган хамгаалах, нийгмийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэн үржлийн ажил үйлчилгээг шинжлэх ухааны үндэслэлтэй зохион байгуулж, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах, ногоон

эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор боловсруулсан уг баримт бичгийг хэрэгжүүлснээр адуун сүргийн тоог жилд 0.8, хонины тоог 1.7, ямааны тоог 1.9 хувиар тус тус бууруулж, үхрийн тоог жилд 0.5, тэмээний тоог 0.3 хувиар өсгөх бодлогыг баримтална.

Стратегийг төлөвлөлтийн дагуу явуулснаар мал сүргийг эдийн засгийн эргэлтэд оруулах, бэлчээрийн даац, тэжээлийн хүрэлцээ хангамжид тохируулах, цөм сүргийн малын тоо, ашиг шимийг нэмэгдүүлж, нийт мал сүргийн чанарыг сайжруулах боломж бүрдэнэ.

Таван төрлийн малын үржлийн ажлын төлөвлөлт, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн тооцоолол



ҮРЖИЛ СЕЛЕКЦИЙН АЖЛЫН ТӨЛӨВӨЛТ

➤ Адуун сүргийн үржлийн ажлын төлөвлөлт:

- Адуун сүргийн удмын санг хамгаалах;
- Уналга-эдэлгээ, хурдлах чадвар болон мах, сүүний ашиг шимийн тодорхой чиглэлээр сонгон үржүүлэх;
- Хурдан морины уралдаан, морин спортын төрлийг хөгжүүлэх;

➤ Үржүүлэх ашиг шимийн чиглэл:

- уналга-эдэлгээ;
- уналга-мах;
- уналга-сүү;
- уналга-хурд-спорт;

2019 он	2029 он
4 214 818	3 710 000



Адууны тоог жилд 0.8 хувиар бууруулна.

2019 он

Шир, толгой,
шийр 618.0

2029 он

Дайвар бүтээгдэхүүн
ширхэг 235.2

Шир, толгой, шийр
1.142.3

Зах зээлд үржилд
163.8

Дайвар бүтээгдэхүүн
ширхэг 521.2

Зах зээлд/амьдаар/
79.8

Зах зээлд үржилд
292.3

Хөөвөр, хялгас, кг
1576.0

Зах зээлд/амьдаар/
99.2


Сүү, литр
114304.5

Хөөвөр, хялгас, кг
1485.0

Мах 36233.7

Мах 76286.1

Сүү, литр 109704.3





ҮРЖИЛ СЕЛЕКЦИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

Үхэр сүрэйн үржлийн ажлын төлөвлөлт:

➤ Үржүүлэх ашиг шимийн чиглэл:

- мах
- сүү
- сүү-мах
- мах-сүү

➤ Урт болон дунд хугацааны зорилт:

- ❖ Нутгийн болон махны үүлдрийн үхрийг өөр дотор нь цэврээр, импортын өндөр ашиг шимт төрөлжсөн үүлдрийг сайжруулагчаар ашиглан ашиг шимийн гарц, чанарыг нэмэгдүүлэх;
- ❖ Сарлагийн үржил-селекцийн ажлыг ашиг шимийг нэмэгдүүлэх боломж, зах зээл, хэрэглээний зүгээс тавигдаж буй шаардлагад нийцүүлэн хөтлөн явуулах;
- ❖ Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн үүлдэрлэг байдлыг сайжруулж, хот суурин газрын хүн амын сүүний хэрэгцээг жилийн турш жилд, тасралтгүй хангах;



Сүүний болон хосолмол ашиг шимт үхэр үржүүлэх

- Цөм сүргээс үржүүлгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, эрчимжсэн аж ахуй эрхлэх бүс нутгийн аж ахуй эрхлэгч фермерүүдэд нийлүүлэх, зохиомол хээлтүүлэгт хамруулах;
- 2025 онд жилд дунджаар 2750-аас доошгүй кг сүү өгдөг 7500 гаруй, 2030 онд жилдээ дунджаар 3250 кг-аас доошгүй сүү өгдөг 7000 толгой үнээг сүүний чиглэлийн үхрийг үржүүлэх тогтоогдсон бүсэд үржүүлэх;
- 2025 онд 25 үнээнд шилжүүлснээр 4000 орчим, 2030 онд 50 үнээнд шилжүүлснээр 3500 гаруй саалийн аж ахуйтай болох;
- 2025 онд хот суурин газрын хүн амын сүү, цагаан идээний хэрэгцээний 60.0 орчим хувийг, 2030 онд 100 хувь хангахуйц сүүг сүүний үхрийн аж ахуйнуудаас нийлүүлэх;
- Сүүний болон хосолмол ашиг шимт үхрийн гарвал ашиг шимийн бүртгэл мэдээллийн санг баяжуулах, 2025 онд сүүний чиглэлийн нийт үнээний 30-40 хувийг, 2030 онд бүртгэлд бүрэн хамруулах;

Махны чиглэлийн үхэр үржүүлэх

- Махны чиглэлийн үхэрт Монгол үүлдэр, Сэлэнгэ үүлдэр, Дорнод талын махны хэвшил, сарлаг хайнаг зэрэг нутгийн үхэр болон Герефорд, Лимузин, Казахын цагаан толгойт, Ангус, Халимаг зэрэг махны чиглэлийн төрөлжсөн үүлдэрүүд, тэдгээрийн эрлийзийг багтаана.
- Махны чиглэлийн нутгийн болон төрөлжсөн үүлдрийн үхэрт жил бүрийн 10-р сард багтаан мэргэжлийн ангилагч-шинжээч ангилалт хийж анги чанарыг тогтоох, сүрэг сэлбэх, чанарын шаардлага хангасан үр болон хөвөрлийг технологийн дагуу бэлтгэн зохиомол хээлтүүлэг хийх, хөвөрөл шилжүүлэн суулгах

Үхрийн тоог жилд 0,5 хувиар нэмэгдүүлнэ.

Ашиг шимийн чиглэл	2019 он	2029 он
Монгол үхэр	3 899 509	5 150 043
Махны чиглэлийн	33 892	55 512
Сүүний чиглэлийн	79 560	199 356
Сүүний болон хосолмол	75 957	112 246



ҮРЖИЛ СЕЛЕКЦИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

➤ Тэмээн сүргийн үржлийн ажлын төлөвлөлт:

- Биологийн боломжийг бүрэн ашиглаж, ашиг шимийн тодорхой чиглэлээр өсгөн үржүүлэх;
- Бүс нутгийн онцлогт тохирсон, чанар стандартын шаардлага хангасан буур, ингэ бойжуулах;
- Зах зээлд өрсөлдөх чадвартай бүтээгдэхүүн үйлдвэрлэж, тэмээчдийн орлогыг нэмэгдүүлэх;


➤ Үржүүлэх ашиг шимийн чиглэл:

- ноос-мах;
- мах-ноос;
- сүү-ноос;
- спорт- уналга, эдэлгээ;

2019 он	2029 он
472 379	498 115



Тэмээний тоог жилд 0,3 хувиар нэмэгдүүлнэ.





ҮРЖИЛ СЕЛЕКЦИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨЛТ

➤ Хонин сүргийн үржлийн ажлын төлөвлөгт :

- Генетик нөөцийн ашиглалтыг сайжруулах;
- Аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг бататгах;
- Зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарц, чанарыг дээшлүүлэх;

➤ Үржүүлэх ашиг шимийн чиглэл:

- мах-өөх - бүүдүүн ноос;
- мах-өөх;
- мах-өөх - бүүдүүтэр ноос;
- нарийн, нарийвтар ноос;
- хурганы арьс;

2019 он 2029 он

32 267 265 24 946 894



Хонины тоог жилд 1.7 хувиар бууруулна.

Ашиг шимийн чиглэл	2019 он	2029 он
Маж-өөх-бүүдүүн ноос	27 150 936	21 479 954
Бүүдүүтэр ноос	1 936 031	2 331 432
Ууцансүүлт	928 801	1 115 852
Нарийн, нарийвтар ноос	15 863	19 656

Ашиг шимийн чиглэл	2019 он		2029 он	
	Тоо	Хувь	Тоо	Хувь
Кашмер хэвшлийн ямаа	25534.3	94.1	21000.0	95.0
Кашгор хэвшлийн ямаа	1582.1	5.8	10000.0	5.0
Ноосны	8.1	0.03	22.0	1.1

➤ Ямаан сүргийн үржлийн ажлын төлөвлөгт :

- Генетик нөөцийн ашиглалтыг сайжруулах;
- Аж ахуй биологийн ашигтай шинж чанарыг бататгах;
- Зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн үүлдэрлэг байдал, ашиг шимийн гарц, чанарыг дээшлүүлэх;

➤ Үржүүлэх ашиг шимийн чиглэл:

- Кашмер ноолуур;
- Кашгор ноолуур;
- Ноосны;

2019 он 2029 он

29 261 661 22 000 000




Ямааны тоог жилд 1.9 хувиар бууруулна.

Хязгаарлагдмал нөөц тархац бүхий мал, амьтны удмын санг хамгаалах зорилгоор 2019 онд Сарлаг үржүүлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж Монгол орны эрс тэс уур амьсгал, өндөр уулын бүсийн бэлчээрт дасан зохицсон, бүтээмж өндөртэй “сарлаг” үхрийн удмын санг хамгаалах, шинжлэх ухааны үндэслэлтэй үржил селекцийн ажлыг явуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлийг тодорхойлов.

МОНГОЛ УЛСАД ӨСГӨН ҮРЖҮҮЛЖ БАЙГАА САРЛАГИЙН ТАРХАЦ, ЦӨМ СҮРГИЙН БАЙРШИЛ

Үндэсний үүлдэр - 1

✓ Монгол сарлаг



Бүс	Нийт сарлаг	
	Тоо	Хувь
Баруун	205 537	19.72
Хангай	834 495	80.05
Төвийн	1 503	0.14
Зүүн	413	0.04
Улаанбаатар	498	0.05
Дүн	1 042 446	100.0

● Сарлагийн цөм сүрэг байршиж байгаа газар нутаг

● Сарлаг байршиж байгаа бусад газар нутаг

Мөн онд нарийн, нарийвтар ноост хонь үржүүлэгчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж бэлчээрийн маллагааны нөхцөлд дасан зохицсон, бүтээмж өндөртэй нарийн, нарийвтар ноост хонийг өсгөн үржүүлэх, ноосны чанарыг сайжруулах, мах, ноос, нэхий үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлж, дотоодын үйлдвэрлэлийг хөгжүүлэх чиглэлийг тодорхойлов.

Ирэх 10 жилд хонин сүргийн тоо, бүтцэд гарах өөрчлөлтийн төлөв

Бүс	2019 он			2029 он		
	хонины тоо, мян.толгой	үүнд:		хонины тоо, мян.толгой	үүнд:	
		хээлтүүлэгч, мян.толгой	хээлтэгч, мян.толгой		хээлтүүлэгч, мян.толгой	хээлтэгч, мян.толгой
Бүдүүн ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт	29 169.6	164.7	13 322.2	21 480.0	188.3	9 671.4
Бүдүүвтэр ноост, махны чиглэлийн өөхөн сүүлт	2 097.4	16.1	935.9	2 331.4	21.1	1 055.1
Махны чиглэлийн ууцан сүүлт	982.9	8,8	481.4	1 115.9	10.3	512.5
Нарийн, нарийвтар ноосны чиглэлийн	15,9	0,1	7,8	19,7	0,2	8,9
Хурганы арьсны	1,5	0,1	1,0	13,4	0,2	9,5
Бүгд	32,267.3	189.8	14 748.3	24 946,9	220,1	11 257,4

Бэлчээрийн даацтай уялдан ирэх 10 жилд хонины тоог 26.4 хувиар бууруулах, харин сүрэгт хээлтүүлэгчийн эзлэх хувийг 14.3 хувиар нэмэгдүүлж, хээлтэгчийг 27.4 хувиар багасгах бодлогыг хэрэгжүүлэх, хонин сүргийн ашиг шимийг боловсруулах үйлдвэр, хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлж үржүүлэх, тэдгээрийн генетик нөөцийг бүрэн ашиглах, ашиг шимийн гарц, чанарыг сайжруулах бодлогыг баримталж ажиллана.

Асуулга 5. Малын ашиг шим үүлдэрлэг байдлыг сайжруулах чиглэлээр малын үржүүлэг, технологийн нэгжүүдийн хийсэн үзлэг, мал ялган тэмдэглэх болон ангилалтын ажил, нэгжүүдэд үзүүлсэн дэмжлэг, санхүүжилтийн талаар / аймаг, он тус бүрээр/:

5.1. Мал үржүүлэг, технологийн ажлын календарчилсан төлөвлөгөө боловсруулан хэвлүүлж, бүх шатны мэргэжлийн байгууллагад зөвлөмжийн хамт хүргүүлж, жил бүрийн 03 дугаар сарын 25-наас 10 дугаар сарын 25-ныг хүртэлх хугацааг Мал үржүүлгийн технологит хугацаа болгон зарлаж, дээрх хугацаанд ажил үйлчилгээний хэрэгжилтийг хангуулж хэвшээд байна.

Технологийн хугацаанд малд үзлэг, ангилалт хийх, баталгаажуулах, цөм сүрэг бүрдүүлэх, стандартын шаардлага хангасан үржлийн малыг Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, удам зүйн үнэлгээгээр гойд ашиг шимтээр шалгарсан малыг үржилд зориулан бойжуулах, борлуулах замаар малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулж, ашиг шимийг нэмэгдүүлэх ажлыг жил бүр зохион байгуулж байна.

Мал сүрэгт үзлэг, ангилалтыг жил бүр тогтмол хугацаанд хийж гүйцэтгээгүйн улмаас малын үүлдэрлэг байдал алдагдах, мал давжаарах, ашиг шим буурах, сүргийн бүтэц алдагдах улмаар эдийн засгийн алдагдал үүсэх нөхцөл болдог тул уг ажилд салбарын яам, орон нутгийн мэргэжлийн байгууллага онцгойлон анхаарч байна.

Хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мал үржүүлэг, технологийн жишиг үнийн тариф болон Мал ангилалтын зааврыг шинэчлэн боловсруулж, батлуулан бүх шатанд мөрдөж ажиллаж байна.

Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлд заасны дагуу 2018-2020 онд улсын төсвийн 976.5 сая төгрөгийн санхүүжилтээр 934.6 мянган мал, орон нутгийн төсвийн 110.0 сая төгрөгийн санхүүжилтээр 223.3 мянган малд үзлэг, ангилалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.

Он	Санхүүжилт /сая.төг/	Үзлэг ангилалт хийсэн аймаг, сумын тоо	Хамрагдсан малын тоо /мян.тол/
2018	256.5	16 аймгийн 54 сум	374.9
2019	290.0	14 аймгийн 71 сум	333.2
2020	430.0	21 аймгийн 99 сум	226.5
Дүн	976.5		934.6

Үзлэг, ангилалтаар цөм, үржлийн, хэрэгцээний сүргийн шаардлага хангасан малд үржлийн бүртгэл хөтөлж, цөм болон үржлийн сүргийн шаардлага хангасан малыг дахин давтагдахгүй хувийн дугаар бүхий ээмгээр ээмэглэх, Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх, удам зүйн үнэлгээнд оруулах ажлыг хавар, намрын технологит хугацаанд хэрэгжүүлж байна.

5.2. Үзлэг, ангилалтыг Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжүүд аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газартай гэрээ байгуулах замаар хэрэгжүүлж байна.

Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах ажлын хүрээнд Мал үржүүлэг, технологийн нэгжүүдийг шинээр байгуулах, үүсгэл санаачилгыг дэмжих ажлыг орон нутгийн мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулав.

2021 оны 1 дүгээр улирлын байдлаар улсын хэмжээнд 22 аймаг нийслэлийн 114 сум, 2 дүүрэгт 137 МҮТАҮН үйл ажиллагаагаа явуулж байна.

Үүний 18 нэгж нь 2020 онд шинээр байгуулагдсан байна.

Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэж буй үзлэг, ангилалт болон бусад мал үржлийн технологит ажлыг орон нутгийн МҮТАҮН-нэгжээр гүйцэтгүүлэх, нэгжийг багаж тоног төхөөрөмжөөр хангах ажлыг бодлогын түвшинд дэмжин ажиллаж байна.

Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн судалгаа

№	Аймгийн нэр	Сумын нэр	№	МҮТАҮН-ийн нэр	№	Шинээр
1	Архангай	Жаргалант	1	Ямаатын их харз	1	2020
		Ихтамир	2	Ихтамирын Итгэл	2	
			3	Ар Чандгана хоршоо	3	2020
			4	Тамир Үржил	4	

		Хангай	5	Арбулган буян ХХК	5	
		Өгийнуур	6	Орхимжит хайрхан ХХК	6	
		Чулуут	7	Марчил хайрхан сүрэг ХХК	7	
		Эрдэнэмандал	8	Том селекц ХХК	8	
			9	Туулант таван эрдэнэ ХХК	9	
		Эрдэнэбулган	10	ОНӨЦөм сүргийн үржлийн төв	10	
			11	Селекц консалтинг-Энх ХХК	11	
		Өндөр-Улаан	12	Өвгөдийн нутаг	12	
		Өлзийт	13	Өгөөж Оюун Хангай	13	2020
		Булган	14	Лусын хур ххк	14	
		Цахир	15	Цахиуртын Ундарга	15	
			16	Цахиур царам хоршоо	16	
		Хотонт	17	ЖИ СИ ЭЛ ХХК	17	
		Батцэнгэл	18	Ихбуян эрдэнэ түмэн сүрэг	18	
		Булган	19	Зураа таван сүрэг	19	2020
2	Баян-Өлгий	Алтай	20	"МЕ-Архалых" ҮҮНэгж	1	
		Сагсай	21	"Хулынды" ҮҮНэгж	2	
		Дэлүүн	22	"Мухтар" ҮҮН	3	
			23	"Бугатөбө" ҮҮНэгж	4	
		Ногооннуур	24	"Егизкөл" ҮҮНэгж	5	2020
		Цэнгэл	25	"Жоль-Говь" ҮҮНэгж	6	
	Өлгий	26	"Уяндөлгөөн" ҮҮНэгж	7		
3	Баянхонгор	Хүрээмарал	27	Ар халзан бугат ХХК	1	
		Баянхонгор	28	Энх нахиа ХХК	2	
			29	Удам судар ХХК	3	
		Жаргалант	30	Нутгийн цагаан шим хоршоо	4	
		Галуут	31	Таван ундрага дархан сүрэг ХХК	5	
		Шинэжинст	32	Залаажинст торгон сүрэг хоршоо	6	
			33	Залаагийн цагаан сувд	7	
		Баян-Овоо	34	Хөвшихтээг ХХК	8	
Бууцагаан	35	Дархан сүрэг хоршоо	9			
Жинст	36	Жинст Мөнгөн сүрэг ХХК	10	2020		
4	Булган	Баян-Агт	37	Шилмэл сүрэг ХХК	1	2020
		Бүрэгхангай	38	Алтанбичигт Цахт ХХК	2	
		ДашинЧилэн	39	Хужирын адаг ХХК	3	
		Гурванбулаг	40	Блек Ангус ХХК	4	2020
		Сэлэнгэ	41	Ингэт сүрэг ХХК	5	
		Хишиг-Өндөр	42	Авзага цэнгэлэн ХХК	6	
		Хутаг-Өндөр	43	Задгай шанд ХХК	7	
5	Говь-Алтай	Цогт	44	"Есөн улаан булаг" ХХК	1	
		Чандмань	45	"Гичгэний хяр" ХХК	2	
		Шарга	46	"Үржил-Алтай" ХХК	3	
		Есөнбулаг	47	"Торгон сүрэг" ХХК	4	
6	Говьсүмбэр	Сүмбэр	48	"Хээнций хангайн сүрэг" ХХК	1	
			49	"Говийн өндөр уул" хоршоо	2	
			50	"Сүмбэр хишигтэн зоо" ХХК	3	
			51	"Сүмбэр зоо" хоршоо	4	
7	Дархан-Уул	Хонгор	52	Хонгор үржил ХХК	1	
		Дархан	53	Мандах он ХХК	2	
8	Дорноговь	Өргөн	54	Сэнж Сант ХХК	1	
9	Дорнод	Баян-Уул	55	"Үет цагааны гол" ХХК	1	
		Цагаан-Овоо	56	"Баян мөнх галуут" ХХК	2	2020
		Халхгол	57	"Утай хан уул" ХХК	3	
10	Дундговь	Хулд	58	Хулд таван эрдэнэ ХХК	1	
		Адаацаг	59	Адаацаг ажнай ХХК	2	
		Сайнцагаан	60	Уудам жаргалант ХХК	3	
11	Завхан	Алдархаан	61	ОКУ САН	1	
		Дөрвөлжин	62	Баатарлаг хоршоо	2	
		Тосонцэнгэл	63	Хатан шонхрын үрс хоршоо	3	

		Эрдэнэхайрхан	64	Сартуул сүрэг	4	
		Яруу	65	Жаргалант мал хоршоо	5	
			66	Уран тэгш	6	
		Идэр	67	Гэгээн нутаг арвин сүрэг ХХК	7	2020
12	Орхон	Баян-Өндөр	68	"Малын генетик нөөц"	1	
		Жаргалант	69	"Манхан-Чүг"	2	
		Арвайхээр	70	Хас Онги ХХК	1	2020
		Гучин-Ус	71	Түсэг хайрхан ХХК	2	
		Арвайхээр	72	Номуунтайван ХХК	3	
		Сант	73	Шинэ цариг БГБХН	4	
		Баянгол	74	Малзүйч үржүүлэгчдийн холбоо	5	
		Хархорин	75	Дархан бор ХХК	6	2020
		Булган	76	ХавцгайтХайрхан ХХК	1	
		Баяндалай	77	Жаргалантын итгэлцэл	2	
		Ханхонгор	78	Цанхын түмэн цагаан	3	
		Ханбогд	79	Гавилууд шилмэл сүрэг	4	
		Эрдэнэцагаан	80	Үзэмчин хонь	1	
		Баруун-урт	81	Дэлгэрэн дэврэх буян	2	
		Мөнххаан	82	Баясгалант сүрэг	3	
		Алтанбулаг	83	Сэлэмт хөшөө	1	
		Шаамар	84	Арын өтөг	2	
		Сүхбаатар	85	Их Цагааны рашаан	3	
		Цагааннуур	86	Хуурч сүрэг	4	
		Түшиг	87	Номтын өндөр	5	
		Сайхан	88	Цөм сүрэг	6	
		Хушаат	89	Төгс гөн	7	
		Орхон	90	Сэлэнгэ Цөм сүрэг	8	
		Баянцагаан	91	"Үйзэн хөх бүрд" ТББ	1	
		Эрдэнэ	92	"Чих булаг" ХХК	2	
		Баяндэлгэр	93	"Өүлэн-Эх" хоршоо	3	
		Баянчандмань	94	"Чандмань үржил" ХХК	4	
			95	"Чандмань алтан төл" ХХК	5	
		Зуунмод	96	"Дэвжих балир-Эрдэнэ" ХХК	6	
			97	"Зоргол-Өнжүүл" хоршоо	7	
		Баян-Өнжүүл	98	"Бүрд баянхангай" ХХК	8	
		Мөнгөнморьт	99	Мөнгөн сүрэг	9	2020
		Батсүмбэр	100	Буган халиуны хишиг	10	2020
		Тэс	101	Таван голын буян /ХХК/	1	2020
		Тариалан	102	Хархираан цөм сүрэг /ХХК/	2	
		Улаангом	103	Дарцагт өндөр /ХХК/	3	2020
			104	Элит удам /ХХК/	4	
		Өмнөговь	105	Салхит ямаат ХХК	5	
		Бөхмөрөн	106	Сэтгэлд шингэсэн 5 эрдэнэ /Хоршоо/	6	
		Хяргас	107	Хуцын үржил	7	
		Алтай	108	Мэнд сүрэг хоршоо	1	
		Булган	109	Малчдын түншлэл Байтаг хоршоо	2	
		Дуут	110	Үржилт шимт сүрэг ХХК	3	
		Зэрэг	111	Зэрэг-Буйлааст хоршоо	4	
		Цэцэг	112	Зуун үржих ХХК	5	
			113	Чандмань ихэр уулс хоршоо	6	
		Чандмань	114	Бумбатын шилмэл сүрэг ХХК	7	2020
			115	Зумъяан голын сүлд ХХК	8	
		Жаргалант	115	Зумъяан голын сүлд ХХК	8	
		Мянгад	116	ГПЭЭЭНН хоршоо	9	
		Баянзүрх	117	Баян алтраг шилмэл сүрэгХХК	1	
		Их-Уул	118	Мандал энх сүрэг ХХК	2	
		Рашаант	119	Өрөлт шилмэл сүрэг ХХК	3	
			120	Рашаант цөм сүрэг ХХК	4	

		Төмөрбулаг	121	Харцагт эрчим ХХК	5	
		Цагаан-Уул	122	Цагаан-Уул ариун сүрэг ХХК	6	
			123	Буянтын буман цагаан ХХК	7	
21	Хэнтий	Галшар	124	"Гал Эрхэм"	1	
		Баянхутаг	125	"Түмэнбат-Анар"	2	
		Цэнхэрмандал	126	"Бор морин дэл"	3	
		Өмнөдэлгэр	127	"Дэлгэр Хурх"	4	
		Биндэр	128	"Ононгийн сүрэг"	5	
			129	"Үржлийн шилмэл сүрэг" хоршоо	6	
		Баян-Адарга	130	"Гурван хужирт хан"	7	
		Батноров	131	"Билгүүн сүрэг" ХХК	8	2020
		Баян-Овоо	132	"Дэлгэрбаян-Эрдэнэ"	9	
		Хэрлэн	133	"Өндөрхаан үржил" хоршоо	10	
			134	"Баян тэргүүн сүрэг" ХХК	11	
135	Хэнтий ЦСҮАА		12			
22	Улаанбаатар	Хан-Уул	136	Үржлийн шилмэл сүрэг хоршоо	1	
		Сонгино хайрхан	137	Нутаг академи ХХК	2	

Асуулга 6. Малын удам гарвал, үүлдэрлэг байдал, ашиг шимийн түвшинг улсын хэмжээнд тодорхойлох, төлөв байдлыг үнэлэх ажил хэдэн хувьтай хийгдсэн талаар /аймаг, он тус бүрээр/:

Монгол Улс нь Дэлхийн тогтвортой хөгжлийн зорилт 2030, Биологийн олон янз байдлын тухай конвенци, Малын генетик нөөцийн талаарх Интерлакены тунхаг болон Даян дэлхийн тогтвортой мал аж ахуйн хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах, олон улсад хүлээсэн үүргийн дагуу Биологийн олон янз байдал, Малын генетик нөөцийн төлөв байдлын талаарх 3 дахь удаагийн үндэсний тайланг Засгийн газрын 2021 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн хуралдаанд танилцуулж, хуралдааны 19 дүгээр тэмдэглэлээр даалгасны дагуу Монгол Улсын Их Хурал, Монгол Улс дахь НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагын Шадар суурин төлөөлөгчийн газарт тус тус хүргүүлээд байна.

Манай Улс малын генетик нөөцийн төлөв байдлын талаарх анхдугаар тайланг 2002 онд, 2 дахь удаагийн тайланг 2015 онд НҮБ-ын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагад хүргүүлж байсан бөгөөд байгаль экологийн болон уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, генетикийн нөөцийг үр ашигтай, тогтвортой ашиглах, хадгалж хамгаалах, судалж хөгжүүлэх, улмаар хүнсний хангамж, хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг тодорхойлж байна гэж үзэж байна.



Мал аж ахуйн салбарт дээрх чиглэлээр өргөн хүрээтэй судалгааны ажлыг 1918-1919, 1947-1951, 1971-1975 онуудад олон улсын эрдэмтдийн багтай хамтран явуулж байсан бол 2019 онд 21 аймаг, 331 сум, 6 дүүргийн хэмжээнд "Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх" судалгааны ажлыг Монголын эрдэмтэдтэй хамтран зохион байгуулж, тайланг 10 жилийн үзүүлэлтэд тулгуурлан гаргасан болно.

Малын генетик нөөцийн төлөв байдлын үндэсний тайлан нь 6 бүлэг, 20 дэд хэсгээс бүрдэх ба Монгол Улсад өсгөн үржүүлж байгаа малын генетикийн олон янз байдал, популяцийн тоо, үүлдэрлэг байдал, газар зүйн тархалтын хувьсал, өөрчлөлт, малын генетик нөөц ашиглалт, түүний эдийн засгийн үр өгөөж, бүтээмж, цаашдын чиг хандлагыг бүс нутаг, аймаг, сум, дүүрэг тус бүрээр гаргаж, улсын хэмжээнд нэгтгэн дүгнэсэн баримт бичиг юм.

Энэхүү тайлан нь Монгол Улсын мал аж ахуйн үйлдвэрлэлийн нөөц боломж, генетик судалгаа, үржил селекцийн стратеги, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, хариу арга хэмжээ авах, төлөвлөх үндэслэлийг нарийвчлан тогтоох, олон улсын тайланд үндэсний тайланг нэгтгэх, баталгаажуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, харилцан мэдээлэл солилцох, баяжилт, нөхөн бүрдүүлэлтийг давтамжтай хийх боломжийг бүрдүүлж буйгаар онцлогтой юм.

Монгол Улсын малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх, судалгаа, экспедицийн ажлыг олон талт хамтын ажиллагаанд суурилан богино хугацаанд амжилттай зохион байгуулж, тус ажлын үр дүнгээр эерэг 34, сөрөг 7 дүгнэлт, 19 зөвлөмж гарсан байна.

МОНГОЛ УЛСЫН БОЛОН ДЭЛХИЙН МАЛ СҮРГИЙН ХУВЬСАЛ ӨӨРЧЛӨЛТ



МОНГОЛ УЛСЫН МАЛЫН ТОО,
малын төрлөөр, аймгаар,
1970-2020 он




ДЭЛХИЙН МАЛЫН ТОО,
малын төрлөөр, улсаар,
1961-2019 он

АДУУН СҮРЭГ

АДУУН СҮРГИЙН НАСНЫ БҮТЭЦ, хүйсээр, 2020 он

Бүгд	Хээлтүүлэгч	Үүнээс шинээр тавьсан	Эхэ жөлийн төл		Өнгөрсөн жөлийн төл		2 настай		3 настай		4 ба түүнээс дээш настай		Хээлтэгч
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм			
4 093 851	153 084	406	419 413	397 155	270 145	254 155	191 220	170 217	164 111	149 890	702 811	1 221 660	1 371 550

АДУУНЫ ТОО, мянган толгой



ДЭЛХИЙД ЭЗЛЭХ БАЙР, 2019 онд



АНУ
10 702.8
мянган толгой



МЕКСИК
6 382.7
мянган толгой



БРАЗИЛ
5 850.2
мянган толгой



МОНГОЛ УЛС
4 214.8
мянган толгой




БНХАУ
3 673.4
мянган толгой

ХАМГИЙН ОЛОН АДУУТАЙ

АЙМАГ:	АРХАНГАЙ	387.8 мянган толгой
СУМ:	СҮХБААТАР ЭРДЭНЭЦАГААН	47.5 мянган толгой
БАГ:	СҮҮХБААТАР БАРУУНУРТ 1-Р БАГ	24.4 мянган толгой


ҮХЭР СҮРЭГ




ҮХЭР СҮРГИЙН НАСНЫ БҮТЭЦ, хүйсээр, 2020 он

Бүгд	Хэлтүүлэгч	Үүнэс шяаэр тавьсан	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл		2 настай		3 ба түүнээс дээш настай		Хэлтэгч
			Эр	Эн	Эр	Эн	Эр	Эн	Эр	Эн	
4 732 010	61 791	342	671 017	640 076	434 083	428 235	296 036	362 580	361 872	1 476 320	1 838 900

ҮХРИЙН ТОО, мянган толгой



ДЭЛХИЙД ЭЗЛЭХ БАЙР, 2019 онд



ХАМГИЙН ОЛОН ҮХЭРТЭЙ

АЙМАГ: АРХАНГАЙ	679.0 мянган толгой
СУМ: АРХАНГАЙ ӨНДӨР-УЛААН	66.7 мянган толгой
БАГ: ӨВӨРХАНГАЙ БАТ-ӨЛЗИЙ 1-Р БАГ	21.8 мянган толгой


ТЭМЭЭН СҮРЭГ




ТЭМЭЭН СҮРГИЙН НАСНЫ БҮТЭЦ, хүйсээр, 2020 он

Бүгд	Хэлтүүлэгч	Үүнэс шяаэр тавьсан	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл		2 настай		3 настай		4 настай		5 ба түүнээс дээш настай		Хэлтэгч
			Эр	Эн	Эр	Эн	Эр	Эн	Эр	Эн	Эр	Эн			
472934	5039	18	41 509	37 538	27 436	24 633	22 248	19 735	19 787	17 772	16 602	16 796	72 754	151 085	167 881

ТЭМЭЭНИЙ ТОО, мянган толгой



ДЭЛХИЙД ЭЗЛЭХ БАЙР, 2019 онд



ХАМГИЙН ОЛОН ТЭМЭЭТЭЙ


АЙМАГ: ӨМНӨГОВЬ	166.8 мянган толгой
СУМ: ӨМНӨГОВЬ ХАНБОГД	32.9 мянган толгой
БАГ: ӨМНӨГОВЬ ХАНБОГД 4-Р БАГ	13.5 мянган толгой

ХОНИН СҮРЭГ


ХОНИН СҮРГИЙН НАСНЫ БҮТЭЦ, хүйсээр, 2020 он

Бүгд	Хэлтүүлэгч	Үүнээс шинээр тависан	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл		2 ба түүнээс дээш настай		Хэлтэгч
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	
30 049 428	183 726	1 291	4 772 427	4 570 505	2 383 768	2 177 300	4 180 297	11 781 405	13 958 705

ХОНИНЫ ТОО, мянган толгой



ДЭЛХИЙД ЭЗЛЭХ БАЙР, 2019 онд



ХАМГИЙН ОЛОН ХОНЬТОЙ


АЙМАГ: АРХАНГАЙ	2 842.6 мянган толгой
СУМ: ХЭНТИЙ ӨМНӨДЭЛГЭР	307.7 мянган толгой
БАГ: СҮХБААТАР БАРУУНУРТ 8-Р БАГ	137.6 мянган толгой

ЯМААН СҮРЭГ

ЯМААН СҮРГИЙН НАСНЫ БҮТЭЦ, хүйсээр, 2020 он

Бүгд	Хэлтүүлэгч	Үүнээс шинээр тависан	Энэ жилийн төл		Өнгөрсөн жилийн төл		2 ба түүнээс дээш настай		Хэлтэгч
			Эр	Эм	Эр	Эм	Эр	Эм	
27 720 253	152 008	703	3 627 910	3 466 398	2 172 675	1 889 058	5 980 737	10 431 467	12 320 525

ЯМААНЫ ТОО, мянган толгой



ДЭЛХИЙД ЭЗЛЭХ БАЙР, 2019 онд




ХАМГИЙН ОЛОН ЯМААТАЙ

АЙМАГ: БАЯНХОНГОР	2 219.2 мянган толгой
СУМ: ХЭНТИЙ ӨМНӨДЭЛГЭР	244.3 мянган толгой
БАГ: СҮХБААТАР БАРУУНУРТ 8-Р БАГ	83.4 мянган толгой

МАЛЧИД

МАЛЧДЫН ТОО, аймгаар, 2019-2020 он /298.7/



МАЛЧДЫН НАСНЫ БҮТЭЦ, хувиар, 2016-2020 он

Насны бүлэг	2016	2017	2018	2019	2020
Бүгд	100,0	100,0	100,0	100,0	100,0
15-34	34,8	34,5	33,9	31,0	29,8
35-54/35-59	55,3	52,6	54,2	56,1	56,8
55+/60+	9,9	13,0	12,5	12,9	13,4


Тайлбар: Эмэгтэй
Эрэгтэй

МАЛЧДЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, 2020 он

Үзүүлэлт	Нийт	Үүнээс:	
		Үндсэн	Туслах
Тар устай	277 485	262 009	15 476
Интернеттэй	66 601	62 191	4 410
Зээлтэй	124 896	119 165	5 731
ИД төлдөг	94 394	89 252	5 142
ЭМД төлдөг	183 092	172 250	10 842
Хоршооны гишүүн	80 733	77 585	3 148
Нөхөрлөлийн гишүүн	23 463	22 403	1 060

МАЛЧИН ӨРХ

МАЛЧИН ӨРХИЙН ТОО, аймгаар, 2019-2020 он



МАЛЧИН ӨРХИЙН БҮЛЭГЛЭЛТ, малын тооны бүлгээр, 2020 он


Малын тооны бүлэг	Малчин өрхийн тоо	Малчин өрхийн малын тоо мянган толгой	Үүнээс:				
			Адуу	Ухэр	Тэмээ	Хонь	Ямаа
Нийт	181 052	60 141,1	3 594,2	3 999,7	447,9	27 161,8	24 917,5
≤10	3 764	24,5	2,8	16,6	0,1	2,1	2,9
11-30	9 925	207,5	21,4	84,7	0,8	42,8	57,8
31-50	9 357	382,6	37,5	101,7	1,5	102,2	139,8
51-100	20 548	1 551,2	137,0	277,8	8,3	496,0	632,2
101-200	38 316	5 684,5	395,7	598,9	33,6	2 100,7	2 555,6
201-500	59 783	19 397,2	1 020,9	1 264,4	133,6	7 994,0	8 902,3
501-999	29 337	20 008,4	1 065,6	1 000,4	155,8	8 490,5	8 296,0
1000-1499	8 320	9 578,7	564,2	458,2	87,4	5 097,5	3 371,3
1500-2000	1 188	1 964,1	145,2	113,1	17,0	1 089,7	599,2
2001+	535	1 342,4	121,9	63,9	9,9	766,4	360,4

МАЛЧИН ӨРХИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

Үзүүлэлт	2016	2017	2018	2019	2020
Цахилгаан үүсгүүртэй	138,3	138,5	136,7	141,7	147,9
Телевизортой	119,7	120,2	119,3	125,4	131,2
Бүх төрлийн автомашинтай	64,1	71,4	79,0	87,8	94,5
Трактортой	5,6	5,4	5,4	5,8	5,4
Мотоциклтой	72,1	76,6	83,6	88,8	88,6
Хийсэн эсгийг мянган метр	36,4	45,9	29,4	22,1	14,3


МАЛЫН ТОО

МАЛЫН ТОО, аймгаар, 2019-2020 он



Төрөл	2016	2017	2018	2019	2020
Малын тоо, мянган толгой					
Бүгд	61 549.2	66 219.0	66 460.2	70 969.3	67 068.5
адуу	3 635.6	3 939.8	3 940.1	4 214.8	4 093.9
үхэр	4 080.9	4 388.5	4 380.9	4 753.2	4 732.0
тэмээ	401.3	434.1	469.7	472.4	472.9
хонь	27 856.6	30 109.9	30 554.8	32 287.3	30 049.4
ямаа	25 674.9	27 346.7	27 124.7	29 261.7	27 720.3
Хувийн өмчийн мал, мянган толгой					
Бүгд	61 183.8	65 857.4	66 107.1	70 583.6	66 709.6
адуу	3 612.2	3 916.9	3 916.2	4 190.5	4 068.6
үхэр	4 045.8	4 351.4	4 340.0	4 710.7	4 688.2
тэмээ	398.7	431.3	466.7	469.6	469.9
хонь	27 648.2	29 906.0	30 358.6	32 047.1	29 850.8
ямаа	25 478.9	27 251.8	27 035.6	29 165.8	27 632.2
Тэжээвэр ямагчид, толгой					
гахай	31 489	31 870	27 819	20 892	24 531
шулуу, мянган толгой	718.7	705.1	886.0	896.7	997.2
цаа буга	2 044	2 228	2 399	2 639	3 127
илжиг, луус	40	44	38	40	30
зөгий, бүл	8 118	9 122	9 791	10 832	11 833
туулай	527	508	150	456	370

МАЛЫН ГЕНЕТИК НӨӨЦИЙН ҮНЭ ЦЭНЭ 2019 он 70.9 сая.тол



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо 2019

Монгол Улсын 5 хошуу мал сүргийн бодит үнэ цэнэ, сая төгрөг /2009-2017 он/

Хуанлийн он	Хэмжих нэг	Бүгд, мян.тол	Үүнээс													Ишиг	
			Адуу	Унага	Үхэр	Тугал	Тэмээ	Ботго	Хонь	Хурга	Ямаа	Ишиг					
2009 он	тоо	44 023,9	2,221.30	420.80	2,599.30	719.10	277	40.1	19,274.70	6,549.40	19,651.50	6038					
	үнэ	2122047.2	375764.4	8416	580417.7	14382	78011.2	802	451748.2	130988	360757.8	120760					
2010 он	тоо	32729,5	1,920.30	274.00	2,176	540.9	269.6	36.4	14,480.40	3,895.80	13,883.20	2651.9					
	үнэ	1982918.1	377661.2	5480	520779.4	10818	79684.4	728	498534.66	77916	358278.47	53038					
2011 он	тоо	36665,8	2,112.90	429.10	2,339.70	662.90	280.1	42.4	15,668.50	5,887.90	15,934.60	5518.5					
	үнэ	2656390.5	488807.1	12873	638693.1	19887	98122.6	1272	602485.0	176637	452058.7	165555					
2012 он	тоо	40920,9	2,330.40	476.90	2,584.60	751.30	305.8	52.5	18,141.40	6,327.90	17,558.70	5770.5					
	үнэ	4538359.7	870589.0	14307	1098696.7	22539	155247.6	1575	1197888.9	189837	814564.6	173115					
2013 он	тоо	45137,2	2,619.4	550.6	2,909.5	845.5	321.5	49.2	20,066.4	845.5	19,227.6	6,488.2					
	үнэ	6929881.7	1305425.4	27529	1595487.5	42274	206698.5	2458.5	2364173.2	42274	1019151.2	324410.5					
2014 он	тоо	51970,4	2,995.8	638.5	3,413.9	974.1	349.3	59.2	23,214.8	8,299.5	22,008.9	7,274.7					
	үнэ	7632207.3	1623708.2	19155	2095788.2	29223	248499.7	1776	1909158.4	248985	1237672.8	218241					
2015 он	тоо	55957,9	3,295.3	726.4	3,780.4	1,135.8	368.0	57.0	24,943.1	9,299.5	23,592.9	7,960.5					
	үнэ	7378008.7	1624572.4	21792	2088705.1	34074	241522.6	1710	1637884.9	278985	1209947.8	238815					
2016 он	тоо	61549,2	3,635.5	740.0	4,080.9	1,158.6	401.4	65.0	27,856.6	9,719.3	25,574.9	8,038.8					
	үнэ	6686015.6	1508555.5	22200	1846893.6	34758	233360.7	1950	1523533.2	291579	982021.6	241164					
2017 он	тоо	66219,0	3,939.80	878.20	4,388.50	1,296.00	434.1	71.0	30,109.90	11,104.90	27,346.70	9291.9					
	үнэ	6614703.7	1343430.1	26346	1815606.8	38880	242468.6	2128.8	1497594	333147	1036345.5	278757					

Монгол Улсын мал сүргийн бодит үнэ цэнэ, бүс, аймгаар /2018 он/

Аймаг, нийслэл	Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Баян-Өлгий	2 233.2	95.4	155.9	5.6	979.6	930.4
ҮНЭ	54,754.38	51447.3	45838.8	3307.0	57015.0	40649.5
Говь-Алтай	3 528.5	130	85.2	43.7	1057.7	2196.8
ҮНЭ	85,657.17	58752.3	40321.4	26904.8	68360.1	105516.4
ТОО	3 615.0	222.5	205	7.8	1827.5	1292.7
Завхан	92,313.54	87041.9	90876.7	5271.7	116750.9	55466.6
ТОО	3 184.2	123.8	182.9	25.1	1568	1275.5
Увс	65,985.69	50769.1	67005.3	15216.6	93441.4	55252.2
ҮНЭ	3 182.6	128.5	193.7	25.4	1174.2	1624.6
ТОО	69,280.72	55216.7	73096.1	14064.1	77241.5	79278.6
ҮНЭ	15 743.5	700.2	822.7	107.6	6607	7320
Баруун бүсийн дүн	2,211,000.33	309977.9	319608.7	65389.4	410524.1	332790.5
ТОО	5 762.1	378.5	621.2	1.3	2981.8	1499.3
Архангай	152,111.78	151486.9	242081.2	624.8	177241.7	71731.8
ҮНЭ	4 420.0	175.9	239.8	57.4	1297.5	2478.9
ТОО	95,115.62	65724.5	95408.2	29391.2	85794.6	120983.5
Баянхонгор	3 306.5	244	255.3	1.4	1778.2	1026.6
ТОО	98,020.32	97186.5	113515.3	833.8	92566.6	50084.5
ҮНЭ	114.60	11.4	17.5	0.1	47.5	38
Орхон	4,816.06	4816.1	7266.7		3348.1	1874.6
ҮНЭ	5 561.0	323.6	272.3	31.5	2588.1	2245.8
ТОО	144,451.18	124422.3	120959.6	20028.9	173331.1	110612.3
Өвөрхангай	5 846.7	262	482.5	2.3	2766.2	2197.5
ТОО	100,334.55	99141.5	176656.9	1193.1	163753.7	101941.6
Хөвсгөл	25 010.9	1395.4	1888.6	94	11459.3	9486.1
Хангайн бүсийн дүн	4,200,287.85	549268.7	778661.5	53423.3	718790.4	465516.1
ҮНЭ	427.50	20.6	14	1.1	208.1	183.7
ТОО	11,441.61	11441.6	7470.1		30831.2	10567.5
Говьсүмбэр	306.20	17.7	44.3	0.1	147.1	97
ТОО						
Дархан-Уул						

	ҮНЭ	8,285.29	21884.0	1956.6	5456.9
	ТОО	2 148.2	80.6	926.2	958.6
Дорноговь	ҮНЭ	88,577.79	41306.9	25285.4	66628.7
	ТОО	3 826.0	76.1	39.3	1831.1
Дундговь	ҮНЭ	107,355.70	42646.6	25832.1	134091.1
	ТОО	2 599.3	26.9	152.3	631.4
Өмнөговь	ҮНЭ	142,412.05	17281.4	93099.5	58232.4
	ТОО	1 540.2	216.8	0.5	705.9
Сэлэнгэ	ҮНЭ	48,508.50	104454.2	224.4	51256.4
	ТОО	4 584.0	282.3	2449.3	1506
Төв	ҮНЭ	160,691.72	134695.9	1942.4	177815.2
	ТОО	15 431.4	741	239.6	6899.1
Төвийн бүсийн дүн	ҮНЭ	2,997,850.36	387516.2	139430.0	538752.2
	ТОО	2 377.9	243.1	6.1	1147.7
Дорнод	ҮНЭ	118,684.84	123415.1	2927.4	57677.8
	ТОО	3 716.8	251.6	8.2	1922.1
Сүхбаатар	ҮНЭ	130,774.97	123980.1	3617.2	104812.1
	ТОО	4 645.2	353	4.3	2353.5
Хэнтий	ҮНЭ	164,879.56	172200.2	2601.7	148742.5
	ТОО	10 739.9	847.7	18.6	5423.3
Зүүн бүсийн дүн	ҮНЭ	2,328,130.33	422828.1	9519.7	325183.9
	ТОО	412.70	80.8	0.2	166.3
Улаанбаатарын дүн	ҮНЭ	111,433.15	31217.8		9914.7
	ТОО	66,460.20	3,940.1	459.7	30,554.8
УЛСЫН ДҮН	ҮНЭ	11,848,702.01	1939832.3	267762.5	2003165.3
					1452353.0

Монгол Улсын мал сүргийн бодит үнэ цэнэ, бүс, аймгаар /2019 он/

Аймаг, нийслэл		Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Баян-Өлгий	ТОО	2192.8	99	93.6	5.9	995.9	933.3
	ҮНЭ	200112.4	60068	21087.3	3511.8	67294.5	48150.7
Говь-Алтай	ТОО	3597.7	132.4	69.7	44.4	1066.7	2269.6
	ҮНЭ	319892.2	65479.6	32282.9	25287.1	76588.6	120254.1
Завхан	ТОО	3849.9	243.7	153.9	8	1950.9	1418.6
	ҮНЭ	396988.3	116467.7	64364.4	5576.9	136534.7	74044.6
Увс	ТОО	3279.6	195.7	187.7	25.6	1604.8	1322.8
	ҮНЭ	488318.8	97807.6	86631	17180.8	113115.5	173583.8
Ховд	ТОО	3084.3	128.8	160.4	25.8	1111.3	1631.3
	ҮНЭ	306600.1	52000.7	62211.1	17456.9	84164.1	90767.2
Баруун бүсийн дүн	ТОО	16004.3	734.5	665.3	109.8	6729.7	7575.7
	ҮНЭ	1579018.6	361065.8	264009.4	71153.1	478105.1	404685.1
Архангай	ТОО	6167	425.9	370.4	1.4	3321.3	1708.4
	ҮНЭ	718896.4	248553.7	129141.9	757.7	239422	101021.1
Баянхонгор	ТОО	4644.9	189.5	257.2	58.1	1406	2733.7
	ҮНЭ	495091.9	85490.2	117231.2	33036.7	103555.5	155778.3
Булган	ТОО	3641.7	272	281.1	126.9	1923.8	1162
	ҮНЭ	589218	136100.2	165835.1	72823.6	146505.9	67953.3
Орхон	ТОО	126.9	12.2	18.96	0.1	50.6	45
	ҮНЭ	23961.4	5680.4	9579.8		5437.3	3263.9
Өвөрхангай	ТОО	5625.5	348.9	175.8	32.7	2606.8	2344.6
	ҮНЭ	593835.7	171167.6	73512.9	22062.6	188485.3	138607.2
Хөвсгөл	ТОО	6040.4	281.8	351.3	2.4	2935.1	2306.7
	ҮНЭ	612812.6	130947.7	137576.1	1458	206521.4	136309.4
Хангайн бүсийн дүн	ТОО	26246.5	1 530.4	1 263.2	96.1	12243.5	10300.4
	ҮНЭ	2953859	746514.6	519090.7	58121.7	988355.7	641776.3
Говьсүмбэр	ТОО	452	22.7	14.5	1	219.5	194.2
	ҮНЭ	49785.2	12161.2	9021		16652.7	11950.4
Дархан-Уул	ТОО	347.4	19.3	47.4	0.1	162.3	118.3

	ҮНЭ	59080	10485.9	26855.6	14409	7329.5
Дорноговь	ТОО	2404.2	152.6	91.9	1021.6	1094.6
	ҮНЭ	328031.4	84042.7	60291.7	72921.9	75502.4
Дундговь	ТОО	4093.1	178.2	78.2	1942.7	1852.8
	ҮНЭ	505744.3	103017.7	54453.5	163992.6	147908.3
Өмнөговь	ТОО	3000.3	109.5	30.6	718.2	1983
	ҮНЭ	437664.7	66583.5	18960.8	69170.1	162126.4
Сэлэнгэ	ТОО	1682.5	103.4	232	744.7	601.6
	ҮНЭ	320889.3	62044.9	149384.1	66093	43367.3
Төв	ТОО	4979.2	371.4	313.1	2619.8	1670.5
	ҮНЭ	767161.1	216776.1	203229.8	229724.2	114926.6
Төвийн бүсийн дүн	ТОО	16958.7	957.2	807.6	5688.5	7515.1
	ҮНЭ	2208259.6	546245.4	504538.2	434593.9	539152
Дорнод	ТОО	2629.6	297.4	277.3	1262.4	786.2
	ҮНЭ	466268.7	151128.6	170116.1	95790.2	45812
Сүхбаатар	ТОО	3817	321.9	267.9	1971.2	1247.4
	ҮНЭ	507553.4	158863.5	163028.7	115775.6	65928.3
Хэнтий	ТОО	4868.4	325.4	380.8	2454.9	1702.6
	ҮНЭ	1210573.2	194953.8	235210.1	286923.3	106269.4
Зүүн бүсийн дүн	ТОО	11315	944.6	926.1	5688.5	3736.2
	ҮНЭ	1718011.8	503958.6	567225	421010	214927.2
Улаанбаатарын дүн	ТОО	444.9	48	84.8	176.7	134.2
	ҮНЭ	102778.4	26210.8	44397.8	20730.7	11439.1
УЛСЫН ДҮН	ТОО	70 969,3	4,214.80	3,747.20	32,267.30	29,261.70
	ҮНЭ	9224925.2	2232251.3	1919785.8	2799092.01	1967656.1

Асуулга 7. Мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, боловсон хүчний хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн батлагдсан орон тоонд мэргэжлийн мал зүйч ажиллуулах, цалингийн шатлалыг нэмэгдүүлэх, улсын байцаагчийн эрх олгох, мал зүйчдийн нийгмийн баталгааг хангах чиглэлээр хийгдсэн ажлын талаар:

7.1.Улсын хэмжээнд 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, 331 сум, мал бүхий 6 дүүрэгт 506 мал зүйч, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, хувийн хэвшилд 1510 мал зүйч мэргэжилтэн төрийн бодлогыг хэрэгжүүлж байна.

ХААИС-ийн Мал аж ахуй, биотехнологийн сургуультай хамтран 4 шатлалаар мал зүйч мэргэжилтэн бэлтгэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан батлуулж жил бүр 25-85 мал зүйч мэргэжилтэн бэлтгэж байна.

Зоо инженер технологи (Мал зүйч) мэргэжлээр элсэн суралцагч, төгсөгчдийн талаарх мэдээлэл

Огноо	Өдөр (4 жил)		Эчнээ анги					
			1.5 жил		2.5 жил		4.5 жил	
	элссэн	төгссөн	элссэн	төгссөн	элссэн	төгссөн	элссэн	төгссөн
2018-2019	56	20	9	*	17	*	9	4
2019-2020	27	26	17	11	15	*	*	*
2020-2021	28	22	5	2	14	6	7	*

Мөн мал зүйч мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах чиглэлээр сургалтын байгууллагатай хамтран бод, бог малын ангилагч, шинжээч бэлтгэх сургалтанд жил бүр 72, мал үржүүлгийн техникч бэлтгэх сургалтанд жил бүр 35 мал зүйчийг хавар, намрын технологит хугацаанд хамруулан мэргэжлийн үнэмлэхийг олгож байна.

Ингэснээр малд үзлэг, ангилалт хийх, гүн хөлдөөсөн үрээр зохиомол хээлтүүлэг хийх эрх нь үүсэж, Мал үржүүлэг, технологийн ажлыг гэрээгээр гүйцэтгэх боломж бүрдэж байна.

Мал зүйч мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг дэв олгох ажлыг холбогдох журмын хүрээнд зохион байгуулж, малын генетик нөөцийг ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх чиглэлээр бүх шатны мэргэжлийн байгууллага, хуулийн этгээдэд зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхийн шалгуур хангасан 26 мал зүйчид ХХААХҮСайдын тушаалаар "Тэргүүлэх мал зүйч" мэргэжлийн зэрэг олгов.

Мөн малын генетик нөөцийг ашиглах, хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх чиглэлээр төсөл, тооцоо боловсруулах, техник, технологийн шийдэлд үнэлэлт, дүгнэлт гаргах, зөвлөгөө өгөх эрхийн шалгуур хангасан 19 мал зүйчид "Монгол Улсын Зөвлөх мал зүйч" мэргэжлийн зэргийг тус тус олгоод байна.

7.2.Улсын хэмжээнд 2021 оны эхний улирлын байдлаар 21 аймаг, нийслэлийн 331 сум, мал бүхий 6 дүүргийн Хөдөө аж ахуйн тасагт нийт 211 мал зүйч мэргэжилтэн ажиллаж байгаа бөгөөд төрийн захиргааны албан тушаалын цалингийн ангилал, сүлжээний ТЗ-З шатлалаар цалинжиж байна.

Мал аж ахуйн салбарын бодлого шийдвэрийг анхан шатанд хэрэгжүүлэх, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасагт нийт ажиллавал зохих 337 мал зүйчээс 211 мал зүйч ажиллаж байна.

Монгол малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, баталгаажсан үүлдэр, омгийн малын удмын санг хамгаалах, үүлдэрлэг байдлыг сайжруулах, цөм сүрэг бүрдүүлэх, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх, удам гарвал, үржил ашиг шимийн чанарыг тодорхойлж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулах үүрэг бүхий мэргэжилтэй боловсон хүчин болох 126 мал зүйч шаардлагатай байна.

Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд сум, дүүргийн Мал эмнэлэг, үржлийн тасгийн /хуучин нэрээр/ мал зүйч мэргэжилтэн нь Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулинд заасны дагуу улсын байцаагчийн эрхтэй байсан тул ТЗ-6 ангилал, шатлалаар цалинжиж байсан болно.

Малын генетик нөөцийн тухай хууль 2018 оны 06 дугаар сарын 01-нээс хэрэгжиж эхэлснээр сумын Мал эмнэлэг, үржлийн тасгийг салгаж, Мал эмнэлгийг босоо тогтолцоотой болгосноор сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч мэргэжилтний албан тушаал нь байцаагчийн эрхгүй болж ТЗ-3 ангилал шатлалаар цалинжиж эхэлснээр цалингийн хэмжээ дунджаар 150 мянган төгрөгөөр буурсан ч ажлын ачаалал нь буураагүй болно.

Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулахад төрөөс тухайлан ямар нэг урамшуулал байхгүй, цалингийн хэмжээ буурсан нь олон жил ажилласан туршлагатай мэргэжилтнүүд ажлаас гарах үндсэн шалтгаан болж байна.

Орон нутагт ажиллаж буй мал зүйч мэргэжилтнүүдэд байцаагчийн эрх олгох, цалингийн шатлалыг нэмэгдүүлэх зэрэг саналыг холбогдох мэргэжлийн байгууллагад хүргүүлэхээр ажиллаж байна.

7.3. Мал аж ахуйн тогтвортой хөгжлийн баталгаа болсон малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх, тогтвортой ашиглах зорилгоор Монгол Улсын Ерөнхий сайдын ивээл дор 2019 онд “Мал зүйчдийн улсын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж, зөвлөгөөнөөс гарсан зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

Мал зүйч мэргэжлийн ажлын байранд хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх хэрэгцээ, шаардлагын талаарх танилцуулгыг бэлтгэж Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллахаар тооцоо, судалгааг гаргаад байна.

2021 оны хавар, намрын технологит хугацаанд 5 аймгийн ХХААГазар, Сумын Хөдөө аж ахуйн тасаг, Малын удмын сангийн үндэсний төв, Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Ноос, ноолуур судлалын лаборатори зэрэгт хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийлгэхээр бэлтгэл хангаж байна.

Асуулга 8. Найдвартай эрүүл мал, хүнстэй болох, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг экспортод чөлөөтэй нийлүүлэх үндэс болсон малыг бүртгэлд хамруулах, ээмэгжүүлэх, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх чиглэлээр хийгдсэн ажлын талаар /хамруулсан болон хамруулах малын тоог он тус бүрээр/:

Улсын Их Хурлын 2010 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн хүрээнд мал сүргийг хувийн дугаартай болгон бүртгэлжүүлж, мал, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний гарал үүслийг тодорхойлох, бүртгэх, хяналт тавих тогтолцоог бий болгож олон улсын жишигт нийцүүлэх зорилт тавьсан.

Уг зорилтын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2011 оны 74 дүгээр тушаалаар “Малыг бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх” журмыг баталж, мал сүргийг дахин давтагдахгүй хувийн дугаар бүхий ээмгээр ээмэглэх, малын бүртгэл, мэдээллийн нэгдсэн программ хангамжийг туршин суурилуулах, нэвтрүүлэх ажлыг 21 аймгийн 330 суманд эхлүүлж, сумын Мал эмнэлэг, үржлийн тасгуудад /хуучин нэрээр/ Малын бүртгэл, мэдээллийн асуудал хариуцсан мэргэжилтнүүд ажиллаж, малын бүртгэл мэдээллийн чиглэлээр хэрэгжүүлж буй бодлого, шийдвэрийг орон нутагт хэрэгжүүлж ажилласан.

“Малын генетик нөөцийн тухай хууль”-ийг баталж, хуулийн 5 дугаар зүйлд малын генетик нөөцийн бүртгэлийн хэлбэр, бүртгэлийг явуулах чиглэлийг заасан бөгөөд “Малын бүртгэлийн журам”, “Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн журам”-ыг тус тус боловсруулж, ХЗДХ-ийн яаманд хүргүүлснээр Монгол Улсын хуулийн нэгдсэн санд бүртгэж, бүх шатны мэргэжлийн байгууллага, мэргэжилтэн, малчид, мал аж ахуй эрхлэгчид дагаж мөрдөж байна.

Малын ялган тэмдэглэх хэрэгсэл /ээмэг, чип/-ийг холбогдох хууль, журам болон Мал, амьтны олон улсын бүртгэлийн хорооны /ICAR/ зөвлөмжийн дагуу гишүүн улс, байгууллага, аж ахуй нэгжийн нийлүүлж буй ээмэг, чипийг ашиглаж байна.

Орон нутгаас ирүүлж буй захиалгыг үндэслэн Засаг захиргааны нэгжийн код бүхий хувийн дугаарыг төрийн захиргааны төв байгууллагаас олгож байна.

Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх ажлыг шат дараатай хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа бөгөөд эхний ээлжинд баталгаажсан үүлдэр, омгийн цөм сүрэг, төрийн болон орон нутгийн өмчит цөм сүрэг, үржлийн нийт хээлтэгч, хээлтүүлэгч, хүнсний зориулалтаар худалдан борлуулах малыг ялган тэмдэглэж, мэдээллийн нэгдсэн санд хамруулах, малын удам гарвал, байршил, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, хүнсний аюулгүй байдлыг хангах зорилт тавин ажиллаж, дараах ажлыг хийж гүйцэтгээд байна. Үүнд:

1.Төрийн өмчит 11 цөм сүргийн үржлийн төвд үржүүлж буй 10.5 мянган малыг үзлэг, ангилалтад хамруулан, бүртгэлгүй 9.2 мянган малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэв.


2.Хот орчмын болон газар тариалангийн бүсийн 7 аймгийн 10.2 мянган бух, 28.2 мянган хуц, 17.2 мянган ухна, 8.1 мянган үнээ, 23.0 мянган эм хонь, 9.0 мянган эм ямаа, нийт 95.7 мянган малыг ялган тэмдэглэж, малын бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэх ажлыг хэрэгжүүлж байна.

3.Дэлхийн худалдааны байгууллагын санхүүжилтээр, Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага, Франц улсын Мал аж ахуйн хүрээлэнтэй хамтран хэрэгжүүлж буй “Монгол Улсын малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх системийг шинэчлэх” /STDF/PG/534/ туршилтын төслийг Өвөрхангай аймгийн 4 суманд /Баянгол, Гучин-Ус, Бат-Өлзий, Уянга/ эхлүүлж, дээрх сумдын 190.0 мянган малыг ялган тэмдэглэж, Өвөрхангай аймгаас хүнсний

зориулалтаар худалдаалах малыг махны үйлдвэрээр дамжуулан нийслэлд хүргэн ажиллаж байна.

4.Малын үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн сангийн программын хөгжүүлэлтийг хийж, хууль журмын дагуу дэд сангуудын холболтыг хийх зорилгоор шаардагдах 150.0 сая төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлэв.

Дээрх ажлыг хэрэгжүүлснээр 2020 оны жилийн эцсийн байдлаар нийт мал сүргийн 15.6% /үүнээс үхэр сүргийн 70%/ буюу 8.5 сая малыг ээмэгжүүлж, 4.5 сая малыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэсэн нь өмнөх онтой харьцуулахад ээмэгжүүлсэн малын тоо 1.5 саяар өссөн, нэгдсэн санд бүртгэсэн малын тоо өсөөгүй байна.



Мал бүртгэлжүүлэлтийн аяныг улсын хэмжээнд зарлаж хэрэгжилтийг хангуулах шийдвэрийг гарган хавар, намрын технологит хугацаанд зорилтот бүлгийн 1.0 сая үржлийн малыг ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх ажлыг зохион байгуулахаар ажлыг эхлүүлээд байна.

Мөн үржилд ашиглаж буй хээлтүүлэгчийг бруцеллёзын шинжилгээнд хамруулах ажлыг Мал эмнэлгийн байгууллагатай хамтран хэрэгжүүлэхээр шийдвэрлээд байна.

2021 онд 3.3 сая толгой (10.3%), 2022 онд 6.6 сая толгой (20.5%), 2023 онд 9.8 сая толгой (30.6%), 2024 онд 13.1 сая толгой (41.1%) малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэхээр зорилт тавин ажиллаж байна.

Асуулга 9. Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зориулан жил бүр төсөвт тусгасан хөрөнгө, санхүүжилт болон генийн сан бүрдүүлэх, хадгалах, хамгаалах чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй төсөл, санхүүжилтийн талаар /он тус бүрээр/:

Малын чанар, үүлдэрлэг байдлыг сайжруулах, ялган тэмдэглэж бүртгэлжүүлэх, үржлийн ажил үйлчилгээний нэгжийг дэмжих, цөм сүрэг бүрдүүлэх,

биотехнологийн ололтыг нэвтрүүлэхэд шаардагдах санхүүжилтыг улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрийн санхүүжилтээр шийдвэрлэхэд онцгой анхаарч байна.

Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд төрөөс анхаарч, Монгол Улсын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд жил бүр тусган хэрэгжүүлэх, бодлогын түвшинд мал сүргийн генетик сайжруулалтыг явуулах, нэг малаас авах ашиг шимийг дээшлүүлэх, мал аж ахуйн үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх боломжийг бий болгоход анхаарна.

Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад зарцуулсан санхүүжилт /сая.төг/

№	Арга хэмжээ	Улсын төсөв, гадаадын төсөл хөтөлбөрөөс олгосон санхүүжилт /сая.төг/							
		Төлөвлөсөн /сая.төг/				Баталсан /сая.төг/			
		2018	2019	2020	2021	2018	2019	2020	2021
1	Баталгаажсан үүлдэр, омгийн малд үзлэг, ангилалт хийх, цөм сүрэг бүрдүүлэх	3.861.3	6020.6	938.0	521.3	256.5	290.0	430.0	430.0
2	Малын генетик нөөцийн төлөв байдлыг тодорхойлох, үнэлэх	21.793.4	27400.4	-	50.0	-	290.0	-	50.0
3	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлэх, хяналтанд авах	5.841.1	6.379.9	6254.9	6.825.7	-	-	-	-
4	Мэргэжилтнийг мэргэшүүлэх, давтан сургах	139.1	151.1	191.4	96.2	-	-	-	-
5	Малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх	7.370.1	8400.8	2016.7	3.760.0	50.0	-	260.0	200.0
6	Гүн хөлдөөсөн үр, үржлийн донор мал худалдан авах	-	600.0		650.0		600.0		650.0
7	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд шаардагдах багаж хэрэгсэл худалдан авах	-	2057.4	1583.3	832.5	-	110.0	108.1	-
8	Малын үндэсний генийн сан бүрдүүлэх	12.930.2	26.046.1	18.814.0	18.000.0	12.930.2	26.046.1	18.814.0	18.000.0

/МУСҮТ-ийн үйл ажиллагааны зардал/									
Нийт дүн	51.935.2	77.056.3	29.798.3	30.735.7	13.236.7	27.336.1	19.612.1	19.330.0	

Асуулга 10. Малын генетик нөөцийн тухай хуулийг дагалдан гарах эрх зүйн акт, заавар, аргачлал, стандарт, нормативыг батлан, хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар:

10.1.Хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалт, шилжилтийн үеийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

-Хууль хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, дагалдан гарах хууль, эрх зүйн актыг боловсруулах, олон нийтэд сурталчлан таниулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулж ажиллуулсан. */Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2017 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн А-174 дугаар тушаал/;*

-Малын генетик нөөцийн тухай хуулийг хэрэгжүүлэх зохион байгуулалтын болон шилжилтийн үеийн бэлтгэл хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг баталж, 12 чиглэлийн 95 арга хэмжээг хэрэгжүүлсэн. */Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2018 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А-07 дугаар тушаал/;*

-Мал аж ахуйн салбарын мэргэжилтэн, эрдэмтэн, судлаач, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан дэд ажлын хэсгийг байгуулж, үйл ажиллагааны хэрэгжилтийг хангах нарийвчилсан хуваарилалт хийж ажилласан. */Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Мал эмнэлэг, үржлийн газар/ хуучин нэрээр /даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ний өдрийн А/04 тоот тушаал /.*

10.2.Хууль тогтоомжийн бусад баримт бичгийг боловсруулах, хэлэлцүүлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Бусад хуулийн давхардал, хийдэл, зөрчлийг арилгахаар боловсруулж, хэлэлцүүлсэн хууль:

№	Боловсруулсан хуулийн төслийн нэр	Биелэлт	Гүйцэтгэл (%)
1	Зөрчлийн тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;	УИХ-ын 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн чуулганы хуралдаанаар хэлэлцэж баталсан. Зөрчлийн тухай хуулийн 13.4 дүгээр зүйлд Малын генетик нөөцийн тухай хуулийг зөрчихтэй холбогдсон 13 заалтыг тусган батлуулсан. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10 дахь хэсэгт мэргэжлийн хяналтын улсын байцаагч хэрэгжүүлэхээр тусган баталсан.	100

2	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;	Хэлэлцэх эсэхийг Засгийн газар, УИХ-ын төсвийн байнгын хорооны хурлаар оруулж дэмжигдсэн. УИХ-ын хаврын нэгдсэн чуулганд хэлэлцэхээр төлөвлөгөөнд тусгагдсан.	80
3	Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах;	Асуудлыг хамтран гүйцэтгэх талаар Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал хүргүүлж, ХЗДХ-ийн Сайдын тушаалаар ажлын хэсэг томилогдон ажиллаж байна.	60

Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон Засгийн газраас шийдвэрлэх асуудлыг боловсруулж, хэлэлцүүлэн батлуулсан тогтоол:

№	Боловсруулахаар төлөвлөсөн асуудлын нэр	Биелэлт	Товч утга
1	Яамдын зохион байгуулалтын бүтэц, орон тооны хязгаар батлах тухай ЗГ-ын 2016 оны 3 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах;	Уг асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг тус тус боловсруулж, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдэж, "Тогтоол, тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2018 оны 187 дугаар тогтоол гарсан.	Яамны үйл ажиллагааны стратегийн зорилтод малын үржил, бүртгэлийн бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах зохицуулах асуудлыг нэмж тусган, орон тоог нэмсэн.
2	Зарим яамдын үйл ажиллагааны стратеги бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлах тухай ЗГ-ын 2016 оны 81 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтад өөрчлөлт оруулах;	Уг асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 8 дугаар сарын 22-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлэн, дэмжигдэж, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 267 дугаар тогтоол гарсан.	Сум, нийслэлийн мал бүхий дүүрэгт Мал эмнэлгийн болон Хөдөө аж ахуйн тасаг байгуулах тухай
3	Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтцийг шинэчлэн тогтоох тухай Засгийн газрын 2016 оны 9 дүгээр тогтоолд өөрчлөлт оруулах;	Уг асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар хэлэлцүүлж, "Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2018 оны 188 дугаар тогтоолоор Засгийн газрын 2006 оны 172 дугаар тогтоолыг хүчингүй болгосон.	Малын удмын сангийн үндэсний төвийг улсын төсөвт үйлдвэрийн газар болгон өөрчлөхөөр шийдвэрлэсэн.
4	Малын удмын сангийн үндэсний төв, цөм сүргийн аж ахуй байгуулах тухай Засгийн газрын 2006 оны 172 дугаар тогтоолыг өөрчлөх;	Уг асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг 2 удаа	МГНТХ-ийн 10 дугаар зүйлийн
5	Шинжлэх ухааны байгууллагуудын талаар авах	Уг асуудлаар Засгийн газрын тогтоолын төслийг 2 удаа	МГНТХ-ийн 10 дугаар зүйлийн

зарим арга хэмжээний тухай ЗГ-ын 2015 оны 27 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах /МААЭШХ/;	боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авсан. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын болон Сангийн сайдын зүгээс дэмжлэг аваагүй тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх асуудал хойшлогдож байсан.	10.7 дахь хэсгийг хэрэгжүүлэх, хүрээлэнгүүдийг яам дэргэдээ авах зорилгоор асуудал боловсруулсан.
---	---	---

Хуулийг дагалдан гарах захиргааны хэм хэмжээ тогтоосон эрх зүйн акт, заавар, аргачлал, стандарт, норматив:

№	Захиргааны актын нэр	Утга	Шийдвэр
1	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний төрөл, жишиг үнэ	Төсвийн хөрөнгө оруулалтаар болон талуудын гэрээний нөхцөлөөр гүйцэтгэх ажлын төрөл, баримтлах жишиг үнийг тогтоосон.	ХХААХҮС-2018- А68 БД-3911
2	Үржлийн малд хянан магадлагаа хийх, баталгаажуулах, үүлдэрлэг байдлыг тодорхойлох, хяналт тавих журам	Монгол Улсад шинээр бий болж буй үүлдэр, омгийн малыг баталгаажуулах асуудлыг зохицуулсан.	ХХААХҮС-2018- А145 БД-3991
3	Мэргэжлийн зэрэг дэв олгох, хүчингүй болгох, сунгах, бүртгэх журам	Мал зүйч мэргэжилтэнд шатлалын дагуу мэргэжлийн зэрэг дэв олгох асуудлыг зохицуулсан.	ХХААХҮС-2019- А42 БД-4264
4	Малын генетик нөөцийн үндэсний зөвлөлдөх хорооны ажиллах журам	Малын генетик нөөцийг хамгаалах, ашиглах, судлан хөгжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх үүрэг бүхий шинжээчдийн багийн үйл ажиллагааг зохицуулсан.	ХХААХҮС-2018- А182
5	Малын генетик нөөцийн үндэсний бүртгэл мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, тайлагнах журам	Малын бүртгэл мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, баяжуулах, баталгаажуулах, тайлагнах харилцааг зохицуулсан.	ХХААХҮС, ҮСХ- ны даргын - 2019-А254, А114 БД-4456
6	Малын бүртгэлийн журам	Малыг ялган тэмдэглэх, бүртгэх, баталгаажуулах, хянах үйл ажиллагааг зохицуулсан.	ХХААХҮС-2019- А501 БД-4621
7	Сайжруулагч малыг үржилд тохируулан сонгох, цөм сүрэг бүрдүүлэх технологийн журам	Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн нэгжид ялган төвлөрүүлэхтэй холбогдох харилцааг зохицуулсан.	ХХААХҮС-2020- А336 БД-4892
8	Гойд ашиг шимт мал шалгаруулах журам	Үржлийн малын үзэсгэлэн худалдаа зохион байгуулж, гойд ашиг шимт мал шалгаруулахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан.	ХХААХҮС-2020- А346 БД-4905
9	Монгол Улсын стандарт Малын үр үйлдвэрлэлд тавигдах ерөнхий шаардлага	Малын үндэсний генийн санг бүрдүүлэх, үржүүлгийн бүтээгдэхүүнийг тусгай орчинд	СХЗГД-2019- С/25

	MNS 4989:2019	хадгалах, үржүүлгийн ажил үйлчилгээ явуулах эрх бүхий байгууллага, аж ахуй нэгжүүд мөрдөнө.	
10	Монгол Улсын стандарт Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжийн бүтэц үйл ажиллагаа MNS 6787:2019	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний үйл ажиллагааны хүрээг тогтоох, үйлчилгээг хүртээмжтэй чанартай явуулах нөхцлийг хангахад мөрдөнө.	СХЗГД-2019- С/47
11	Монгол Улсын стандарт Мах-өөхний бүдүүн бүдүүвтэр ноост хонь Ерөнхий шаардлага MNS 1997:2019	Мах-өөхний бүдүүн, бүдүүвтэр ноост хонь үржүүлдэг малчид, аж ахуй нэгж, иргэд, байгууллагад хамаарна.	СХЗГД-2019- С/53
12	Монгол Улсын стандарт Монголын нарийн нарийвтар ноост хонь Ерөнхий шаардлага MNS 2623:2019	Нарийн нарийвтар ноост хонийг үржүүлэх, үржилд зориулан бойжуулах, борлуулах, удам зүй, ашиг шимийн үнэлгээ хийх аж ахуй нэгж, иргэд, байгууллагад хамаарна.	СХЗГД-2019- С/47
13	Монгол Улсын стандарт Монгол үүлдэр, омгийн адуу Ерөнхий шаардлага MNS 4099:2020	Монгол үүлдэр, омгийн адуу үржүүлж ашигладаг малчид, мал бүхий иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийн хооронд үүсэх харилцааг зохицуулахад хамаарна.	СХЗГД-2020- С/49

10.3.Хуулийг олон нийтэд сурталчлан таниулах чиглэлээр дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

-Хуулийн эмхэтгэлийг 4 удаа, 5200 ширхэг, хялбаршуулсан 3 төрлийн брошюр 8000 ширхэгийг тус тус хэвлүүлэн, 21 аймаг, нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, салбарын харьяа байгууллагууд, Хөдөө аж ахуйн их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, 331 сумын Засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн тасагт хүргүүлсэн;

-Мал үржүүлэг, технологийн ажлын календарчилсан төлөвлөгөөг боловсруулан хэвлүүлж бүх шатны мэргэжлийн байгууллага, аж ахуй эрхлэгчдэд хүргүүлэв;

-Мал үржүүлэг, технологийн ажлын болон мал бүртгэлжүүлэлтийн чиглэлээр 2 төрлийн контент бэлтгэн олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацаж мэдээлэх ажлыг зохион байгуулав;

-Хөдөө аж ахуйн салбарын нэгдсэн, бүсийн болон орон нутгийн салбар зөвлөгөөнд хуулиудын талаар илтгэл мэдээлэл бэлтгэн, сурталчилж, нийт 1746 мэргэжилтэн, улсын байцаагч, орон нутгийн удирдлагуудад танилцуулав.

Асуулга 11. Хуулийн биелэлтийг хангуулах талаар цаашид хэрэгжүүлэхээр төлөвлөж буй бодлого, арга хэмжээний талаар:

Малын генетик нөөцийн тухай хуулийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр 2021-2024 онуудад дараах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлнэ. Үүнд:

1. Малын генетик нөөцийн төлөв байдлын үнэлгээнд тулгуурлан Монгол малын удмын санг алдагдуулалгүй зорилтод зах зээлд чиглүүлэн ашиг шимийг тогтвортой нэмэгдүүлэх үржлийн хөтөлбөрүүдийг боловсруулж, хэрэгжилтийг хангах;

2. Малын чанар, бүтээмж нь тооны өсөлтөөс хоцорч байгаад анхаарч, мал сүргийг өсгөх талаар ялгавартай бодлого баримталж адуу, хонь, ямааны өсөлтийг зохистой түвшинд тогтвортой хадгалах, үхэр болон тэмээний тоог өсгөхөд чиглэсэн үржил селекцийг шинжлэх ухааны үндэслэлтэй явуулахад мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах;

3. Түүхий эд, бүтээгдэхүүний бэлтгэн нийлүүлэлт, борлуулалтыг нэмэгдүүлэх, бүх шатанд уялдаа холбоог сайжруулах зорилгоор хоршоогоор дамжуулан түүхий эд, бэлтгэл, ангилан ялгалтын ажлыг зохион байгуулж, түүхий эд, бүтээгдэхүүнд чанарын үзлэг шинжилгээ хийхэд анхаарах;

4. Малыг ялган тэмдэглэж, бүртгэлжүүлэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх ажлыг хууль тогтоомжийн хүрээнд эрчимжүүлж, мал, малын гаралтай бүтээгдэхүүний гарал үүсэл, шилжилт хөдөлгөөнийг хянах тогтолцоог сайжруулах;

5. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн ажил үйлчилгээний нэгжид ялган төвлөрүүлэх замаар бэлчээрийн малын чанарыг сайжруулах ажлыг эрчимжүүлж, сум бүрт Мал үржүүлэг, технологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулах 1-2 загвар нэгжийг бий болгож үр дүнг тооцох;

6. Сум, дүүргийн Хөдөө аж ахуйн тасгийн батлагдсан орон тоонд мэргэжлийн мал зүйч ажиллуулах, мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх, давтан сургах, мэргэжилтэй боловсон хүчний хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэхэд сургалтын байгууллагатай хамтран ажиллах;

7. Малын генетик нөөцийн төлөв байдлыг 3 жил тутамд тодорхойлж, тайлагнадаг, үндэсний тайланг 5 жил тутамд Олон Улсад тайлагнах ажлыг тогтмолжуулах;

8. Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүнс, хөдөө аж ахуйн байгууллага дахь Гэрийн тэжээвэр амьтдын олон янз байдлын мэдээллийн системд өмнө нь бүртгэгдсэн үүлдэр, омгийн малын тоо, мэдээллийг шинэчлэх, нэмж бүртгэх, баяжуулах ажлыг эрчимжүүлэх;

9. Малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийг бүртгэх, түгээн дэлгэрүүлэх ажлыг үр дүнтэй хэрэгжүүлэх;

10. Мал аж ахуйн салбарын бүх түвшинд хүний нөөцийн хангамжийг бүрдүүлэх, чадавхижуулах, мэргэжлийн болон технологийн хяналтын тогтолцоог сайжруулах;

11. Малын генетик нөөцийг хадгалах, хамгаалах, судлан хөгжүүлэх, бүртгэх, мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг улсын болон орон нутгийн төсөвт тусгуулж, хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн бодлогоор тууштай дэмжих зэрэг болно.

-----oOo-----